

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Гурав. Сахилга хариуцлага, болон авилгаас урьдчилан сэргийлэх ажлын талаар

Дөрөв. Соён гэгээрүүлэх ажил болон албаны сургалтын талаар

Тав. Санхүү, бүртгэл, хангамж үйлчилгээний талаар

Зургаа. Дотоод хяналт, шалгалтын талаар

Долоо. Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

Найм. Дүгнэлт

Ес. Санал

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНТ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 10 дугаар
сарын 04-ны өдөр.

Хэрлэн сум.

Цагдаагийн газар 2022 онд Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, Хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэд технологийн ашиглалтыг нэмэгдүүлэх, алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах, тасаг албад, алба хаагч бүрийн ажлын бүтээлч чанар, үр дүнг өнгөрсөн оныхоос ахиулах зорилт тавин ажиллалаа.

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Цагдаагийн газраас Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн сайд болон аймгийн Иргэдийн хурал, Засаг дарга нараас гаргасан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын өгсөн үүрэг, шийдвэрийг алба хаагчдад судлуулах, тайлбарлан таниулах, бие бүрэлдэхүүнийг шинэ мэдээ мэдээллээр ханган тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан 5 зорилт, 63 заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх журам”-ын /код 108/ дагуу 5 зорилт 98 ажил, арга хэмжээ бүхий цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд долоо хоног бүрийн “Баасан” гаригт дотоод журмын дагуу цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, тушаал шийдвэр, холбогдох эрхийн актууд, байгууллагын бодлого чиглэл, цаг үеийн ажлын талаар тогтмол мэдээлж, албад, алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой, нэн шаардлагатай зарим бичиг баримтыг хувилж олшруулан тарааж, хэрэгжүүлэх талаар үүрэг чиглэл өгч байна.

Тус Цагдаагийн газрын хэмжээнд 2022 оны 3 дугаар улиралын жилд нийт 844 бичиг хүлээн авч газрын удирдлагад танилцуулан хариуцсан алба хаагч нарт нь хувиарлан бүртгэлээр өгч, цагдаагийн газраас нийт 683 албан бичгийг хүргүүлж, явуулсан бичгийн бүртгэлд хөтөлж ажиллав.

Цагдаагийн газрын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргийн ажлыг ахиулахад анхаарах асуудал, ажиллах орчин, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, алба хаагчдаас санал хүсэлтийг хүлээн авч удирдлагын түвшинд шийдвэрлэх зорилгоор “Алба хаагчаа сонсьё” арга хэмжээг зохион байгуулж сарын бүрийн 01-ны өдрийг “Алба хаагчаа сонсох” өдөр болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсч хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагч, ажилтны бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор “Үндэсний бөх”-ийн барилдааныг зохион байгууллаа.

Монгол Улсад Төрийн хяналтын тогтолцоо үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулсан “Волейболын тэмцээн”-д Спортын дэд мастер Б.Ядамжав ахлагчтай Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын баг тамирчид “Тэргүүн байр” эзлэв.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагч, ажилтны бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хөл бөмбөгийн спортыг хөгжүүлэх, зорилгоор зохион

байгуулагдаж байгаа Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын 2022 оны Зүүн бүсийн “ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА” шалгаруулах тэмцээн Говьсүмбэр аймагт амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Хэнтий Төв аймгийн Цагдаагийн газар, хэлтсийн баг тамирчид оролцож, “Тэргүүн” байранд цагдаагийн хурандаа Т.Ганзориг даргатай Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын баг тамирчид шалгарч аваргын шилжин явах цом, алтан медаль, Өргөмжлөлөөр шагнагдлаа.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсч хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд “Намар эрүүл цагдаа-гэр бүл” өдөрлөгийн үйл ажиллагааг “Баянтүмэн натурал виллаж” амралтын бааз дээр Цагдаагийн газрын хамт олон, гэр бүлийн дунд зохион байгуулж Өдөрлөгөөр тасгууд мэндчилгээ, хүүхдийн гар зургийн уралдаан, дартс шидэлт, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, хөгжөөнт буухиа тэмцээний төрлөөр хурд хүч, авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдүүлж тасагуудыг байр эзлүүлж шагнаж, урамшуулав.

Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ны үйл ажиллагааг “Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл” НҮТББ-ын тэргүүн Г.Адилбиш болон нэр бүхий нутгийн иргэд хамтран 5 шаардлага тавьж эсэргүүцэж газрын тосны тээвэрлэлт явуулдаг төв замд 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 13-ны өдрүүдэд жагсаалыг зохион байгуулагдах үед тус тасгийн алба хаагчид хэв журам сахиулах хамгаалалтын үүргийг гүйцэтгэн ажилласан.

А. Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал: Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал: Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгүүлж, долоо хоног бүрийн Мягмар гаригт 12 удаа хуралдаж, 199 асуудал хэлэлцсэнийг ангилж үзвэл: Удирдамж төлөвлөгөө батлах 14, ажлын байрны томилолт болон чөлөөлөх асуудлаар 62, шагнаж урамшуулах 12, албаны шалгалт 6, сахилга хариуцлагын талаар 6, ажлын хэсэг байгуулах талаар 22, тасаг албадын сарын ажил дүгнэх талаар 9, хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг авч хэлэлцэх талаар 9, сонсгол мэдээлэл 50, бусад асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан ба зөвлөлийн хурлаас 9 алба хаагчид хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлт үр дүнг тооцсон байна.

Албадын дарга нарын манлайлал, бүтээлч ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүй, цагдаач шуурхай ажиллагааг хангаагүй, шат дараалсан шаардлага, хяналт сул байгаа байдлыг юуны түрүүнд сайжруулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засаж арилгах, орон нутгийн цагдаагийн тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр газрын даргын 39 үүрэг, ажлын чиглэлийг албан бичгээр хүргүүлж, биелэлт үр дүнг нь тооцож ажиллалаа. Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр бүрэлдэхүүнд 39 удаа үүрэг тавьж, давхардсан тоогоор 25 алба хаагчтай ганцаарчлан уулзаж зөвлөгөө өгч, 20 алба хаагчийн гэр бүлийн гишүүдтэй уулзаж ярилцан зөвлөгөө өгч, санал хүсэлтийг нь сонсов.

Б. Хүний нөөцийн талаар:

Цагдаагийн газар нь цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, алба хаагчдын эрх зүйн баталгааг хангах, ажлын таатай орчныг бүрдүүлж мэдлэг боловсрол ухамсраа дээшлүүлэх боломжоор хангах, хүн төвтэй цагдаагийн үйлчилгээний тогтолцоог бий болгох, ил тод нээлттэй байж өргөдөл гомдлыг хүлээн авах барагдуулах ажлыг боловсронгуй болгох, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан иргэдэд мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж байгууллагын нэр хүндийг дээшлүүлэхэд өдөр тутам анхаарч ажиллаж ирлээ.

Цагдаагийн байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан иргэдийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”, “Хүний нөөцийг судлах, ажилд томилох /код 901/ журам”-ын дагуу сонгон шалгаруулалт зарлаж, цагдаагийн байгууллагад ажилд орох хүсэлт гаргасан 10 иргэнийг бүртгэн шаардлага шалгуур хангасан 2 иргэний материалыг Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн сонгон шалгаруулалтад хамруулав.

Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/135 дугаар тушаалаар батлагдсан 191 алба хаагчийн орон тоо батлагдаж, нийт байвал зохих 200 алба хаагч байхаас одоогийн байдлаар бэлэн

185 алба хаагч /Дотоодын цэргийн 826 дугаар тусгай салбарт 23 алба хаагч/ ажиллаж байна.

Алба хаагчдыг хүйсийн байдлаар нь авч үзвэл 167 буюу 83,5 хувь нь эрэгтэй, 12 буюу 6 хувь нь эмэгтэй, 103 буюу 60 хувь нь офицер, 63 буюу 37 хувь нь ахлагч, 5 буюу 2,9 хувь нь энгийн

гэрээт ажилчид байна. Алба хаагчдыг насны байдлаар нь ангилж үзвэл 21-25 насны 21, 26-30 насны 53, 31-35 насны 52, 36-40 насны 24, 41-45 насны 15, 46-50 насны 6 алба хаагч байна.

Цагдаагийн байгууллагад ажилласан жилээр нь ангилж үзвэл 1 жил хүртэл 8, 1-5 жил ажилласан 43, 6-7 жил ажилласан 18, 8-10 жил ажилласан 21, 11-15 жил ажилласан 38, 16-20 жил ажилласан 24, 21-25 жил ажилласан 4, 26-гаас дээш жил ажилласан 2 алба хаагч байна. Тус Цагдаагийн газарт өнөөдрийн байдлаар 8 /Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга 1, Сэтгэл зүйч 1, эдийн засгийн мөрдөгч 2, хэсгийн байцаагч 3, цагдаа-жолооч 1 алба хаагчийн орон тоо дутуу байгаа болно.

Цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хамт олны дунд нэр хүндтэй, ажлын дадлага, чадвар, туршлагатай, албаны мэдлэг чадвар сайтай нэр бүхий алба хаагчдын гаргасан санал хүсэлт, боловсрол мэргэжлийн түвшин, дадлага, туршлагыг харгалзан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Албан тушаал дэвшүүлэх” /код 909/ журамд заасан болзол шаардлагыг хангасан алба хаагчдыг байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн 2022 оны эхний 3 дугаар улирлын байдлаар тасаг хэсгийн даргаар 2, ахлах албан тушаалд 1, офицер бүрэлдэхүүнд оруулсан 2, ажлын байр өөрчлөгдсөн 25, шинээр томилогдсон 16 алба хаагч байна.

В. Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар:

Цагдаагийн газрын удирдлага, албан тушаалтанд хандаж иргэд, аж ахуй, нэгж байгууллагаас эхний 3 дугаар улирлын байдлаар 167 өргөдөл, гомдол, санал ирүүлснийг хүлээн авч бүрэн шийдвэрлэж хариу өгөв. Ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг ангилбал ажил өөрчлөх шилжихийг хүссэн 44, захиргааны чөлөө хүссэн 123 байна.

Цагдаагийн газрын удирдлага алба хаагчдын талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол мэдээлэл, дотоодын хяналт, шалгалтаар илрүүлсэн зөрчил бүрийг бүртгэн авч албаны шалгалт явуулан шалтгаан нөхцөлийг тогтоож буруутай этгээдэд хариуцлага тооцох, буруугүй болох нь тогтоогдсон алба хаагчийн талаар гомдол мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэж байгууллагын болон алба хаагчийн нэр төрийг сэргээхэд анхаарч ажиллав.

Г. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тухай: Аймгийн Прокурорын байгууллагатай “2022 онд хамтран ажиллах төлөвлөгөө” боловсруулан Цагдаагийн газрын дарга, Ерөнхий прокуророор энэ оны 01 дүгээр сарын 20-ний өдөр батлуулж, мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих прокуроруудтай сар бүр уулзалт, улирал бүр зөвлөгөөнийг зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн газрын дарга, аймгийн Ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар “Эрэл” хэсэгчилсэн арга хэмжээг 01 дүгээр сард зохион байгуулж арга хэмжээний хүрээнд гэмт хэрэгт сэрдэгдсэн 3 этгээдийг, оргодлоор зарлагдсан 1 этгээдийг олж тогтоон ажилласан.

Улсын ерөнхий прокурорын орлогч, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга нарын 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хамтран баталсан “Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Дорнод аймаг дахь цагдаагийн газраас шийдвэрлэх хэргийн графикт орсон хэргүүдээс шийдвэрлэн үр дүнтэй ажиллаж байна.

Аймгийн Шүүхийн шинжилгээний албатай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгууллагын удирдлагуудаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Энэ оны гуравдугаар улирлын байдлаар Шүүхийн шинжилгээний албанд криминалистикийн 54, үүнээс гарын мөрний 36, мөр судлалын 18 шинжилгээ хийлгэж, шүүх эмнэлгийн 170, үүнээс гэмтлийн зэрэг тогтоох 45, бэлгийн холбогдолтой 15, задлан шинжилгээ 99, химийн 20, биологийн 30 шинжилгээ хийлгэн ажиллахад нэмэлт 16 шинжилгээ хийлгэсэн нь нийт шинжээч томилсон хэргийн 1.9 хувийг эзэлж байна.

Аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болон Шүүхийн тамгын газартай хамтарсан зөвлөгөөнийг 2022 оны 02 дугаар сард зохион байгуулан зөвлөгөөний үеэр “Эрүүгийн хэрэг шийдвэрлэхэд анхаарах асуудал” сэдэвт 02 цагийн сургалтыг алба хаагч нарт явуулав.

ХОЁР. ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн хэмжээнд 2022 оны 09 дүгээр сард 337 холбогдогчтой, 1.540.2 төгрөгийн хохиролтой, 533 гэмт хэрэг бүртгэгдэж, 140 хэргээр буюу 36 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 36.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 206 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 2 буюу 14 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 36 буюу 21 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 420.6 төгрөг буюу 27.3 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн гаралт: -Хэрлэн сумын 1, 2, 4, 6, 7, 10, 11 дүгээр багууд, Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот, Баянтүмэн, Гурванзагал, Булган, Матад, Халхгол сумдуудад өсөж, Хэрлэн сумын 5, 8, 9 дүгээр багууд, Чойбалсан, Сэргэлэн, сумдад буурсан байна. Хэрлэн сумын 3, дүгээр багууд Цагаан-Овоо, Хөлөнбуйр ижил түвшинд байна.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 112 бүртгэгдэж 47 буюу 72 хувь, Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 37 бүртгэгдэж 25 буюу 29.4 хувь, Галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин, хүүхэд оролцсон гэмт хэрэг 17 бүртгэгдэж 7.5 дахин тус тус өсөж

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг хэрэг 30 бүртгэгдэж 7 буюу 19 хувиар буурч, Мансуурсан үедээ үйдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 29 хүн холбогдсон нь 9 буюу 24 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 12 бүртгэгдэж 5 буюу 29,4 хувиар тус тус буурсан

Үйлдэгдсэн газраар: - Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 59 бүртгэгдэж 10 буюу 20 хувь, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 37 бүртгэгдэж 23 буюу 1.6 дахин, Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 5 бүртгэгдэж 4 буюу 4 дахин, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 47 бүртгэгдэж 22 буюу 88 хувь, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 33 бүртгэгдэж 7 буюу 27 хувь, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 120 бүртгэгдэж 46 буюу 62.8 хувь, Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 22 бүртгэгдэж 1 буюу 5 хувиар тус тус өссөн байна.

Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 13 бүртгэгдэж 8 буюу 38.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийн төрлөөр: - Хүнийг алах 6 бүртгэгдэж 1 буюу 20 хувь, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 50 хувь, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 192 бүртгэгдэж 30 буюу 19 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 3 дахин, хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдэж 58 буюу 1.05 дахин, залилах гэмт хэрэг 78 бүртгэгдэж 32 буюу 70 хувь, Хөрөнгө завших гэмт хэрэг 13 бүртгэгдэж 4 буюу 44 хувь, гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 буюу 25 хувь, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах 1 бүртгэгдэж 100%, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100%, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 1 буюу 33.3%, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 18 бүртгэгдэж 1 буюу 6 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 11 бүртгэгдэж 4 буюу 57 хувиар өсч

Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 буюу 50 хувь, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 бүртгэгдэж 2 буюу 14 хувь, халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 буюу 20 хувь, мансууруулах эм сэтгэгдэл нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 21 бүртгэгдэж 3 буюу 14 хувиар тус тус буурч

Дээрэмдэх гэмт хэрэг 3, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж ижил түвшинд байна.

Хүүхдийн эсрэг, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, авлигын эсрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58 буюу 1.05 дахин өсөж үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 97 бүртгэгдэж 48 буюу 98 хувь өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 40 бүртгэгдэж 4 буюу 11 хувиар өссөн байна. гэмт хэргийн илрүүлэлт 36.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан байна.

Б. ЦАГДААГИЙН ГАЗРЫН ТАСАГ, АЛБАДААС ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР

ЭРҮҮГИЙН ЦАГДААГИЙН ТАСАГ: Эрэн сурвалжлах ажлын талаар: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-229/-ын 11 дэх заалтыг баримтлан 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/62 тоот тушаалаар цагдаагийн газрын эрэн сурвалжлах ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, эрэн сурвалжлах “Asap” сангийн ашиглалт, бүрдүүлэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн даргаар ахлуулан 8 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж, “Орон тооны бус зөвлөл”-ийг 14 хоног тутам хуралдуулж, эрэн сурвалжлах ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, мал, амьтан, эд зүйлийг эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэх, шинээр томилогдсон алба хаагчдыг эрэн сурвалжлах “ASAP” сантай ажиллахад сурган дадлагажуулах зорилгоор цахим сургалтыг тогтмол зохион байгуулан, ЦБҮАЖ /код-229/-ын 229.16.1-д заасныг хэрэгжүүлэх чиглэлээр цагдаагийн газрын дотоод журамд заасан хуваарийн дагуу долоо хоног бүрийн баасан гарагт эрэн сурвалжлах ажлын нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар бие бүрэлдэхүүнд танилцуулж, “Эрэн сурвалжлах ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх тухай”, “Эрэн сурвалжлах “Asap” сангийн ашиглалтыг сайжруулах тухай” албан даалгаврыг гаргаж түүний албан даалгаврын хэрэгжилтэд “эрэн сурвалжлах ажил хариуцсан, орон тооны бус ажлын хэсэг” хяналт тавин ажиллаж байна.

Эрэн сурвалжлах “asap” сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн талаар:

Эрэн сурвалжлах “Asap” санд зарлагдсан эрэн сурвалжлалтын мэдээллүүдтэй алба хаагчдыг тухай бүр танилцуулах талаар 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 11*/917 дугаартай үүргийн хүрээнд алба хаагчдыг “Asap” сангийн зарлан мэдээлэлтэй танилцах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, 7 хоног бүрийн баасан гарагт зарлан мэдээлэлтэй танилцаагүй алба хаагчдын нэрсийг хүн нэг бүрээр танилцуулж хэвшсэнээр 2022 оны эхний 09 сарын байдлаар тус цагдаагийн газрын 211 алба хаагчид эрэн сурвалжлах, мэдээллийн “ASAP” санд зарлагдсан 89,351 зарлан мэдээлэлтэй танилцсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзвэл зарлан мэдээлэлтэй танилцсан алба хаагчдын тоо 120 нэгжээр нэмэгдэж, санд зарлагдсан мэдээлэлтэй танилцсан тоо 75,624 нэгжээр буюу 6.5 дахин өссөн байна.

Эрэн сурвалжлагдсан хүн, мал, эд зүйлийг олж тогтоосон талаар:

Эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” сангийн ашиглалт 2022 оны эхний 09 сарын байдлаар мэдээлэл бүртгэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийхэд алба хаагчдаас эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” санд 365 зарлан мэдээллийг оруулснаас 185 зарлан мэдээллийг олж тогтоон зогсоож, төвлөрсөн тоо бүртгэлд авснаар тус цагдаагийн газрын “Asap” сангийн илрүүлэлтийн хувь 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 50.6%-тай байна.

Одоогийн байдлаар санд энэ оны 180, урьд оны 35, нийт 215 зарлан мэдээлэл шийдвэрлэгдээгүй байна.

МӨРДӨН БАЙЦААХ ТАСАГ: Тус тасгаас хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн урьд оны үлдэгдэл 26, энэ оны эхний 09 сард 543, нийт 569 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 307 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 84 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 156 гомдол мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж шийдвэрлэн, 2 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлж, 20 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй ажилласан.

Урьд оны үлдэгдэл хэрэг бүртгэлтийн 35, энэ оны эхний 09 сард шинээр нээсэн болон харьяаллын дагуу шилжиж ирсэн 129 хэргийг хүлээн авч, нийт 164 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 76 хэргийг хааж, 56 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 10 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэн 22 хэргийн үлдэгдэлтэй ажилласан.

Нийт шийдвэрлэсэн хэргээс өмнө оны үлдэгдэл 12 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 17 хэргийг хааж, 5 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн байна.

Мөрдөн байцаалтын 345 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 298 хэргийг шүүхэд шилжүүлэх, 17 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт хүргүүлж, 15 хэргийг нэгтгэн, 4 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 11 хэргийн үлдэгдэлтэй ажиллалаа.

Энэ оны 09 дүгээр сарын байдлаар Шүүх, прокуророос нэмэлт мөрдөн байцаалтад 8 хэрэг буцсан байна. Тус тасагт түдгэлзүүлсэн хэрэг байхгүй болно.

Тус тасагт энэ оны гуравдугаар улирлын байдлаар олон үйлдэл, холбогдогчтой, ээдрээ төвөгтэй, хугацаа хэтэрсэн, олны анхаарал татсан хэрэг шалгагдаагүй байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан яллагдагчтай 14 хоног тутам уулзаж мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авч, хэргийг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авч, мөрдөгч нар цагдан хоригдож байгаа яллагдагчтай 7 хоног тутам уулзаж тэмдэглэл хөтөлж байгаад хяналт тавин ажиллалаа.

Мөрдөн байцаах албаны даргын 2022 онд баталсан хүрэх түвшин, нэгжийн болон алба хаагчийн ажлыг дүгнэж, үнэлэх шалгуур үзүүлэлтийг ханган биелүүлж буй байдал, мөрдөн шалгах ажиллагааны чанар үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын ажлыг шалган зааварчлах, илэрсэн зөрчил дутагдлыг засуулах, урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах /Код 112/ журамд заасны дагуу удирдамж төлөвлөгөө боловсруулан цагдаагийн газрын даргаар батлуулж, 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдрөөс 05 дугаар сарын 02-ны өдрийн хугацаанд шалгалт явуулж, үр дүнг танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг засах, ажил эрчимжүүлэх чиглэлээр алба хаагч тус бүрд зөвлөмж өгч ажилласан болно.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа "Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх /код 201/ журам"-д заасны дагуу энэ онд тус аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн олны анхаарал татсан, хүний амь нас хохирсон, цагдаагийн алба хаагчтай холбоотой, хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн, хугацаат цэргийн алба хаагч нас барсан зэрэг гэмт хэргийн талаар ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авсан даруйд Мөрдөн байцаах албаны дарга болон чиглэл хариуцсан хэлтсийн дарга нарт холбоо мэдээллийн хэрэгслээр мэдэгдэж, бичгээр 18 хэргийн танилцуулгыг хүргүүлж, удирдлагыг мэдээллээр ханган үүрэг, ажлын чиглэл авч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай зохион байгуулан ажиллалаа.

ЗАМЫН ЦАГДААГИЙН ТАСАГ: Цагдаагийн газрын даргын баталсан хуваарийн дагуу нийт 132 алба хаагчид өөрсдийн хариуцсан аж ахуйн, нэгж, байгууллагуудад дээрх мэдэгдлийг хүргүүлж, баяр, наадмын үеэр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах чиглэлээр яриа, таниулга хийж ажилласан.

Баяр, амралтын өдрүүдэд үйлдэгдэж болзошгүй зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх санамж, сэрэмжлүүлэг гарган орон нутгийн МИЖИ, Шинэ суваг, TV6, DTV зэрэг телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр болон цагдаагийн газрын албан ёсны сайтаар иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав.

Цагдаагийн газраас баяр, амралтын өдрүүдэд “Буйр” нуур, “Халхын” гол, “Онон” гол, “Хэрлэн” голын ойр орчимд иргэдийн хөдөлгөөн ихэссэнтэй холбогдуулан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын цагдаагийн тасаг, хэсгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт чиглэл өгч өдөр бүр эргүүл, шалгалтыг эрчимжүүлж, ногоон бүс, голын эрэг орчимд иргэдийг нэвтрүүлэхгүй байх талаар арга хэмжээ авч, өдөр тутмын явган болон мотоциклтой эргүүлээс гадна 24 цагийн пост гарган үүрэг гүйцэтгүүлж, иргэдэд санамж, зөвлөмж хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Мөн орон нутгийн замд гарч байгаа зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, осол хэргийн гаралт, үүнээс үүдэлтэй нас баралт, гэмт зэрэг хохирлыг багасгах, авто замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, иргэд таатай зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн шторкыг Дорнод аймгийн иргэдийн хандалт ихтэй page, facebook группд тогтмол байршуулах, орон нутгийн телевизүүдээр өдөрт 2 удаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Дорнод аймгийн Хөлөнбуйр, Булган, Сэргэлэн, Цагаан-Овоо, Дашбалбар, Баяндун, Баян-Уул, Матад, Халхгол, Чойбалсан, Гурванзагал, Чулуунхороот сумдын баяр наадамд хамгаалалтын үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, санамж тараах материалыг наадамчин олонд түгээж ажиллалаа.

Дорнод аймаг Халхгол сумын Засаг дарга Б.Хүрэлсүхэд Улаанбаатар хотоос Дорнод аймгийн Халхгол сум Буйр нуур чиглэсэн иргэдийн хөл хөдөлгөөн ихсэж байгаа тул Мэнэнгийн заставын огцом эргэлт, мөн их бурхантын замын нүх зэрэг замын эвдрэл гэмтэл их байна. Иймд амралт зугаалгын цаг ирж байгаа үед иргэд жолооч нар орон нутгийн батлагдсан замаар өөрсдийн дур мэдэн явнаас болж, замдаа төөрч будилах, мөн нүх, гуу, жалганд орж эрүүл мэндэд хөрөнгөөр хохирол учирч байгаа тул энэ тал дээр анхаарч ажлаа шаардлагатай байна.

Хот хоорондын зам болон хөдөө орон нутгийн замд хөдөлгөөнд оролцогчдод Монгол улсын Замын хөдөлгөөний хууль, дүрмийн заалтыг сахин биелүүлж, цаг үеийн гэмт хэрэг, осол, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын нөхцөл байдалд хурдыг зөв тохируулан явах, тээврийн хэрэгслийнхээ техникийн стандартын шаардлага хангаж хөдөлгөөнд оролцох чиглэлээр 3 төрлийн 1500 ширхэг “**САНАМЖ**” хуудас, “Аажуу явбал аяандаа хүрнэ дээ” уриалга бүхий 2 төрлийн 5000 ширхэг зөвлөмж хуудас хэвлүүлэн орон нутгийн замд хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгсэлийн жолооч нарт тарааж ажилласан.

Дорнод аймгийн Цагдаагийн гараас улсын хэмжээнд зохион байгуулсан зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх “Аажуу явбал аяандаа хүрнэ дээ” нэгдсэн арга зохион байгуулах, сурталчлах ажилд зориулан орон нутгийн зам дагуу 7x3, 2x1 мөн бүх сумдад 2x1 хэмжээтэй самбар байрлуулах зардалд Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 5.000.000 /таван саяг төгрөг/ шийдвэрлүүлсэн.

“Аажуу явбал аяандаа хүрнэ дээ” нэгдсэн арга хэмжээг сурталчлах, хариуцсан нутаг дэвсгэртээ зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнд оролцож байгаа зорчигч, жолооч нарт зам тээврийн осол, хэргийн шалтгаан, хор уршгийг ойлгон таниулж, замын хөдөлгөөнд оролцогч нар болон нийгэмд учруулж буй хор хохирлыг бууруулах, иргэд жолооч нарт хөдөлгөөнд оролцох зөв дадал, сахилга, хандлагыг бий болгох ажлыг иргэдийн тусламжтай зохион байгуулах зорилгоор “Иргэд зөвлөж байна” хэсэгчилсэн хэмжээг зохион байгуулав.

“Зам тээврийн гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, мотоцикл холбогдсон зам тээврийн ослыг бууруулах иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлд байгаа улсын бүртгэлд бүртгүүлээгүй мотоцикл бүрийг судалгааг гаргах зорилгоор “Мотоцикл” тооллого арга хэмжээг зохион байгуулах удирдамж төлөвлөгөөг гарган зохион байгуулж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 3 дугаар улиралын байдлаар зам тээврийн гэмт хэрэг ослын шинжтэй 35 дуудлага мэдээлэл бүртгэгдэн шалгагдсан, гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 19 хүн гэмтсэн байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Бүртгэгдсэн гэмт хэрэг, осол 35 буюу 8 нэгжээр өссөн бол, гэмтсэн хүн 19 нэгж буюу өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, харин зам тээврийн ослын улмаас нас барсан хүн 3 буюу 2 нэгжээр буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Гудамж замын хяналт шалгалтаар 4943 зөрчил илрүүлэн ажилласнаас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 377, эрхийн үнэмлэхгүй болон эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл

жолоодсон 255, нийт түр саатуулах үндэслэлээр 415 тээврийн хэрэгслийг түр саатуулж, замын хөдөлгөөний хууль, дүрмийг бусад байдлаар зөрчсөн 4313 жолоочид 115,123,000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээг бэлэн бусаар оногдуулан 233 жолоочийн эрхийг хасаж 51 жолоочийг шүүгчийн шийтгэвэрээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулах арга хэмжээ оногдуулж ажилласан байна.

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ТАСАГ: Тус тасгийн алба хаагчдаас иргэд байгууллага аж ахуйн нэгжээс нийт 642 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас 100 гомдол мэдээллийг зөрчлийн хэрэг нээж, зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай 414 гомдол, мэдээллийг прокурорт шилжүүлж, хялбаршуулсан журмаар 102 гомдол, мэдээллийг шийдвэрлэж 472 иргэн, 10.735.000₮ /Арван сая долоон зуун гучин таван мянган/-н төгрөгийн торгууль оногдуулж, 28 иргэнийг шүүхээр баривчлуулж, зөрчил гаргасан, биеэ авч явах чадваргүй болтлоо согтсоны улмаас гудамж, талбай олон нийтийн газар унтсан нийт 1179 иргэнийг эрүүлжүүлж, 108 иргэнийг ар гэр, асран хамгаалагч, эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Алба хаагчдаас 2022 оны 3 дугаар улиралд 8 гэмт хэргийг илрүүлж, 15 гэмт хэргийг таслан зогсоож, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 6 мэдэгдэл бичиж, ЦБҮА-ны /код 307/ журмын дагуу гэмт хэргийн талаар 28 илтгэх хуудас бичиж танилцуулан, эрэн сурвалжлах сангийн мэдээлэлтэй 55 алба хаагч давхардсан тоогоор 574 удаа орж, 29042 мэдээлэлтэй танилцсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн, хэсэгчилсэн, тусгай арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр алба хаагчдаас санал авч нэгтгэн Цагдаагийн газрын даргаар батлуулан хуваарийн дагуу алба хаагчдаас арга хэмжээг зохион байгуулж байгаа байдал, үр дүнг тооцон ажиллаа. 2022 онд тус тасгаас зохион байгуулахаар төлөвлөсөн 118 арга хэмжээнээс 3 дугаар улиралд төлөвлөгөөний дагуу 29 хэсэгчилсэн болон нэг бүрчилсэн арга хэмжээг зохион зохион байгуулаад байна.

Тайлангийн хугацаанд алба хаагчдад хугацаатай үүрэг, ажлын чиглэлийг бичгээр өгч, давхардсан тоогоор 225 алба хаагчид нийт 316 заалт бүхий 15 төрлийн зааварчилга, 40 заалт бүхий 3 төрлийн зөвлөмж хүргүүлэн, офицер алба хаагч нарт үүрэг даалгавар дэвтрээр 7 хоногт хийх ажлын чиглэлийг өгч биелэлтийг тооцон ажиллав.

Нэгдсэн эргүүл шалгалтыг 12 удаа, хүч нэмэгдүүлсэн шалгалтыг 13 удаа, “эргүүл шалгалт” нэгдсэн арга хэмжээ, хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс нийтийн эргүүл гарган зохион байгуулан үр дүнг тооцож ажилласан байна. Эргүүлд давхардсан тоогоор 1230 алба хаагч, 1950 цагийн үүрэг гүйцэтгэсэн бөгөөд эргүүлийн хуваарь томилгоог 7 хоног бүр гаргаж, цагдаагийн газрын даргаар батлуулан хуваарийн дагуу алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангуулан гаргаж, үйл ажиллагааг 165 удаа шалгаж, үүрэг, зааварчилгаар өгч ажилласан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ᠗᠗᠗᠗᠗᠗᠗᠗ 9 аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл, санамж өгч, 328 байгууллага, аж ахуйн нэгжээр гадаад дотоод орчимд нь камерын хяналт, гэрэлтүүлэг ᠔᠗᠗᠗᠗᠗᠗, 4 байгууллагыг нийтийн эргүүлд татан оролцуулж, давхардсан тоогоор 157 айл өрхөөр орж санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, нийт 2800 орчим иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийж, хорих ялаас чөлөөлсөн хугацааны өмнө суллагдсан 12 этгээдэд хяналт тавьж ажилласан.

Гэмт хэрэгтэй тэмцэх илрүүлэх чиглэлээр нийт ЦБҮАЖурам /код-307/ -оор 14 илтгэх хуудас, мэдээ мэдээлэл бичиж танилцуулан, 1 хэрэг, зөрчил илрүүлсэн байна.

Хэрлэн сумын 2, 3 дугаар багийн хэсгийн байцаагч нар “Камер хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай төлөвлөн зохион байгуулж, 17 аж ахуйн нэгж байгууллагад хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дохиолол хамгаалалт, камержуулалтаа шийдвэрлэх хугацаатай мэдэгдэл хүргүүлснээр 15 аж ахуй нэгж байгууллага камержуулалтаа бүрэн шийдвэрлэж, 2 аж ахуйн нэгжийн камер чанарын шаардлага хангаагүй байсныг дахин хугацаатай мэдэгдэл хүргүүлж бүрэн камержуулж ажилласан. Энэ арга хэмжээг зохион байгуулснаар тухайн нутаг дэвсгэрт үйлдэгдэх хулгайлах гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 30 хувиар гэмт үр дүн гарсан байна.

Хэрлэн сумын 1 дүгээр багийн хэсгийн байцаагчаас нуугдмал гэр бүлийн хүчирхийлэл, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг бууруулах чиглэлээр 2022 оны эхний 1 дүгээр улиралд багийн ажлын алба, хамтарсан багийн хүрээнд хариуцсан нутаг дэвсгэр дэх 1470 өрхөөс гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 45 иргэнийг сонгон судалд, эмзэг бүлгийн 8-13 насны 18 хяналтдаа авч, гэр бүлээр нь хүлээн авч уулзалт, ярилцлагыг зохион байгуулж ажилласнаар гэмт хэрэг өмнө оноос 64 хувиар буурч, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэмт хэрэг 78 хувиар буусан байна.

Хэрлэн сумын 9 дугаар багийн хэсгийн байцаагчаас хариулсан багийн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэдэд мэдээ мэдээлэл өгөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх ажлыг багийн ажлын алба, хамтарсан багтай хамтран зохион байгуулсан. Аяны хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийг энэ төрлийн гэмт хэргийн

хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, яриа таниулгыг Хэрлэн сумын 9 дүгээр багийн хэсгийн ахлагч нар, “Анхдагч өргөө”, Чойбалсан өргөө, Өв тэгш өргөө, Дөрвөн өргөө СӨХ-ын ажилтнууд, 1, 9, 10-р цэцэрлэгийн багш, ажилчид эцэг эхчүүд, 1-р сургуулийн 10-12 ангийн сурагчдад, АА-ын холбоотой хамтран зохион байгуулсан.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааны талаар: Тус Цагдаагийн Эрүүлжүүлэх, саатуулах байр нь Монгол Улсын үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль, Хууль зүйн, дотоод хэргийн сайдын 2017 оны А/185 дугаар тушаалаар батлагдсан “Саатуулах байрны дэглэм, журам”, Эрүүлжүүлэх байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ MNS5527:2019, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/39 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Захиргааны журмаар албадан саатуулах /код 623/ журам, А/40 дүгээр тушаал: “Албадан эрүүлжүүлэх /код 630/ журам”-аар зохицуулагдан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 9 сарын байдлаар эрүүлжүүлэх байранд 1999 хүн зөрчлийн улмаас эрүүлжүүлэгдсэн байна. Үүнээс эрэгтэй-1882 эмэгтэй-117, насанд хүрээгүй хүүхэд-3, гадаадын иргэн-0 бүртгэгдсэн байна.

Эрүүлжүүлэгдсэн нийт хүмүүсийг багаар нь авч үзэхэд: 1-р багаас-263, 2-р багаас-284, 3-р багаас-139, 4-р багаас-253, 5-р багаас-16, 6-р багаас-213, 7-р багаас-123, 8-р багаас-38, 9-р багаас-136, 10-р багаас-165, тодорхой оршин суух хаяггүй-106, Улаанбаатар хотын харъяат-13, хөдөө орон нутгаас-62 тус тус бүртгэгдэж, Булган сумаас-157, Баян-түмэн сумаас 18, Цагаан-Овоо сумаас-51, Баян-Уул сумаас-25, Баяндун сумаас-5, Дашбалбар сумаас-9, Сэргэлэн сумаас-6, Чулуунхороот сумаас-7, Гурванзагал сумаас-4, Чойбалсан сумаас-4, Матад сумаас-19, Халхгол сумаас-7, Хөлөнбуйр сумаас-7, бусад аймгаас 12 хүнийг албадан эрүүлжүүлж холбогдох бүртгэл тэмдэглэлийг хөтлөн, эрүүл мэндийн үзлэгийг хийж хяналтандаа авч ажилласан байна.

Цагдаагийн газрын дотоод сүлжээнд 1999 картыг шивж, Шүүх шинжилгээний албаны папилон санд 349 хүний гарын хээг шинээр авч бүртгэлд оруулсан.

Тайлангын хугацаанд Эрүүлжүүлэгдсэн нийт 1999 хүнээс өдөрт нь төлбөр хураамж авсан-1461, нөхөн төлсөн-214 хүн, нийт 1675 хүнээс 6951250/ Зургаан сая есөн зуун тавин нэгэн мянга хоёр зуун тавин/ төгрөгийн төлбөр хураамжийг авч, төлбөрийн тайланг тухай бүрт нь санхүү албанд хүргүүлэн ажилласан. Төлбөр төлөлт 83,7 %-тай барагдуулсан байна.

Эрүүлжүүлэх байрны хамгаалалт, гэрэлтүүлэг, дохиолол, телехяналтын болон дуу бичлэгийн хэрэгслийн хэвийн эсэхийг тогтмол шалган алба хаагч, үйлчлүүлэгч нарын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай алба /102/-т суурьлуулсан нэгдсэн /төв/ телекамер болон тус эрүүлжүүлэх байранд байрлуулсан нэмэгдэл камеруудын тусламжтайгаар байранд тавих хяналтыг 24 цагаар тасралтгүй явуулж алба хаагч, үйлчлүүлэгч нарын аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Нийтийн хэв журам хамгаалах тасгийн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн алба хаагчид эхний хагас жилд батлагдсан хувиар томилгооны дагуу шүүхийн байранд 24 цагаар 80 удаа гарч 1920-н хүн цагийн үүрэг гүйцэтгэж ажиллаа. Тус шүүхээр үйлчлүүлэхээр нэвтэрсэн 3150 иргэний бичиг баримтыг шалган бүртгэж нэвтэрүүлэн хяналт тавьж ажилласан.

Тус хэсгийн хамгаалалтын цагдаа нар Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хурал 322, Иргэний хэргийн анхан шатны шүүх хурал 424, Зөрчилийн хэргийн хурал 413, Захиргааны хэргийн анхан шатны шүүх хурал 20 нийт 1179 шүүх хурлын дэг журам сахиулж ажилласан. Үүнээс шүүх хуралдаанд давхардсан тоогоор шүүгч-1377, улсын яллагч 873, нарийн бичгийн дарга 1179, өмгөөлөгч 203, шүүгдэгч 352, хохирогч 105, хариуцагч 224, нэхэмжлэгч 394, зөрчилд холбогдогч 241, гэрч 21, бусад 78 тус тус оролцсон. Олон оролцогчтой болон олон нийтийн анхаарал татсан шүүх хурал явагдах үед хэсгийн алба хаагчаас нэмэгдлээр ажиллуулж байна.

ШШГГазрын Цагдан хорих байрнаас шүүхийн байр хүртэл 72 удаа 151 яллагдагч, шүүгдэгч ялтанг /насанд хүрсэн эрэгтэй 150, насанд хүрсэн эмэгтэй 1/ шүүхийн байрнаас ШШГГазрын цагдан хорих байр хүртэл 78 удаа 182 шүүгдэгч, /насанд хүрсэн эмэгтэй 2, насанд хүрсэн эрэгтэй 180/ ялтанг албаны автомашинаар нийт 150 удаа 333 яллагдагч, шүүгдэгч, ялтанг хуяглан хүргэсэн. ЭХАШШүүхээс захиргааны зөрчлөөр баривчлагдсан 321 иргэнийг ШШГГазрын ЦХБайр руу 47 удаа явганаар хуяглан хүргэлт хийсэн.

Шүүхийн байранд архи согтууруулах ундааны зүйл хэргэлсэн үедээ нэвтрэхийг завдсан зөрчил илрүүлэж шүүгчийн туслахад мэдэгдэн ар гэрт нь хүлээлгэн өгсөн.

Цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүргийн дагуу хэсгийн алба хаагчд өдөр болон оройн эргүүлд 6 удаа 36 хүн/ цагийн үүрэг гүйцэтгэж 102 дуудлага мэдээлэл 29 хүлээн авч эрүүлжүүлсэн 13, ар гэрт нь 5 иргэнийг хүлээлгэн өгч шийдвэрлэж ажилласан.

Шүүгчийн захирамжаар 21 хүн нийт 39 хүнийг олж тогтоон холбогдох албан тушаалтан болон нэхэмжлэгч нарт хариу мэдэгдэж ажилласан.

Шүүхийн харуул хамгаалалтын цагдаа нарын шүүхийн харуулын байранд үүрэг гүйцэтгэх томилгоог 7 хоног бүр шинэчлэн гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан, хуваарийн дагуу алба хаагчдыг томилон ажиллуулж хэвшсэн бөгөөд, сар бүрийн эхэнд “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 514” /Нууц үг дугаар батлах/ дагуу Цагдаагийн газрын даргаар нууц үг дугаарыг батлуулан өдөр тутмын харуул хамгаалалтын томилгоо хийхдээ алба хаагчдыг өдөр оройн эргүүлд томилох зэргээр удирдлага зохион байгуулалтаар ханган нийтлэг үүргийн дагуу шүүхийн харуул хамгаалалтын цагдаа нар нийт 44 удаа 312 цагийн үүрэг гүйцэтгэж 7 хүнийг 70000 төгрөгөөр торгож цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах “ASAP” сантай 1480 удаа танилцаж ЦБҮЖ код 307-оор 21 илтгэх хуудас санд шивж ажилласан байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Нийтийн хэв журам хамгаалах тасгаас аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цагаан сар, Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр”, хүн, малын гоц халдварт өвчний үеийн хамгаалалт, Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ны үйл ажиллагааг “Нутгаа авраха Чойбалсанчуудын нэгдэл” НҮТББ-ын тэргүүн Г.Адилбиш болон нэр бүхий нутгийн иргэд хамтран 5 шаардлага тавьж эсэргүүцэж газрын тосны тээвэрлэлт явуулдаг төв замд 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 13-ны өдрүүдэд жагсаалыг зохион байгуулагдах үед хэв журам сахиулах хамгаалалтын үйл ажиллагааг зөрчил дутагдалгүй зохион байгуулж ажиллалаа.

ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТАСАГ: “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /код-701/ журам”-ийн хэрэгжилтийг хангах үүднээс 2022 оны эхний хагас жилийн байдлаар иргэд байгууллагаас нийт 3679 гомдол мэдээллийн хүлээн авч мэдээллийн сангийн гомдол мэдээллийн санд шивж оруулан ажилласан. Гэмт хэргийн мэдээллийн санд 1183, зөрчлийн санд 2496 мэдээлэл шивэгдсэнийг хянаж, баталгаажуулан мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаж, мэдээлэл бүрийг төвлөрсөн тоо бүртгэлд бүртгэн авч ажилласан.

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар гэмт хэргийн шинжтэй 1183 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаснаас 556 буюу 56.9 хувьд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 549 гомдол мэдээлэл буюу 46.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 4 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу бусад байгууллага руу шилжүүлсэн байна. Зөрчлийн шинжтэй 2496 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 385 буюу 15.4 хувьд нь зөрчлийн хэрэг нээж, 1343 буюу 53.8 хувийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, 696 буюу 27.8 хувийг зөрчлийн шинжгүй гэх үндэслэлээр татгалзаж шийдвэрлэж, 12 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу бусад байгууллага руу шилжүүлсэн.

Тасгийн дарга нарыг “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээллийн сан бүрдүүлэх /код-701/ журам”-ын 701.6.3, “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх /код-702/ журам”-ын 702.6.3 дахь хэсэгт заасан эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавьж, цаашид тасгийн дарга нарын зүгээс цахим санд тогтмол хяналт тавих, ажлыг хэвшүүлэхээр хоногийн мэдээний програм хангамжинд өдөр тутам тасгийн дарга нарын цахим санд тавьж байгаа хяналтын талаарх мэдээллийг шивж оруулсан.

2022 оны 3 дугаар улирлын байдлаар гэмт хэргийн тоо бүртгэлийн санд 3574 мэдээлэл маягт бүртгэгдсэнээс тасгийн дарга нарын хянасан мэдээлэл нийт 3553 буюу 99.4%, саатуулагдсан хүний бүртгэлд 1943 маягт бүртгэгдсэнээс 1941 буюу 99.8%, зөрчлийн мэдээллийн санд 4160 маягт бүртгэгдсэнээс тасгийн дарга нар 4126 буюу 99.1 хувийг тус тус хянаж ажилласан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/ журам”, “Зөрчлийн тоо бүртгэл хөтлөх /код 702/ журам”-ыг хэрэгжүүлэх, мэдээллийн сангийн ашиглалт, бүрдүүлэлтийг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр “**Зөрчлийн хохирогч**”, мөн оны 08 дугаар сарын 12-ны өдөр “**Алдаанаасаа суралцахуй**”, мөн оны 09 сарын 15-ны өдөр “**Эрүүгийн хэргийн тулгалт-хяналт 2**” зэрэг хэсэгчилсэн болон тусгай арга хэмжээнүүдийг зохион байгуулж алба хаагч нар сургалт орж ажилласан.

Цагдаагийн байгууллагаас иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг судлан үзэх эрх бүхий байгууллагад үзүүлдэг лавлагаа, мэдээллийн үйлчилгээг ойртуулах, шуурхай болгох зорилгоор 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны Лавлагааны сангаас олгодог тодорхой төрлийн лавлагааг орон нутгийн цагдаагийн газраас олгодог болсонтой холбогдуулан, хүүхэд үрчлэн авах, овог нэрээ өөрчлөх, төрийн байгууллагад ажилд орох зэрэг тодорхойлолт лавлагааг Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системээс зөрчилд холбогдож байсан талаар лавлагаа авахаар хандсан 36 албан бичгийн 241 иргэнд иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх лавлагааг, алба хаагч нараас захиргааны хяналтаны ХӨТЯШ-тэй иргэдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсэх талаарх лавлааг давхарсан тоогоор 2, эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа этгээдүүд эрүүгийн хариуцлага хүлээсэн эсэх талаарх лавлагааг давхардсан тоогоор 211, иргэний гэмт хэрэг зөрчилд холбогдсон

талаарх лавлагаа тус тус мэдээллийн сангаас шалган өгч цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэв..

“Цагдаагийн газрын Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” чиглэлээр хийсэн ажлын танилцуулгыг 7 хоног бүрийн “Баасан” гарагт нийт алба хаагчдад танилцуулж, илэрсэн зөрчил, цаашид хэрэгжүүлэх ажлын санал, анхаарах асуудлын талаар мэдээллийг тогтмол хүргүүлж ажилласан.

“Дорнод аймгийн телехяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-ын төслийг боловсруулж, аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Журмын төслийг 2022 оны 10 дугаар сард багтаан батлуулахаар төлөвлөөд байна.

Цагдаагийн газрын дарга, “Чойбалсан хөгжил” ОНӨҮГазрын даргын 2022 оны 01 дүгээр улиралд “Гудамж зам талбайн телехяналтын камерын ашиглалт, хамгаалалтын байдлыг хангах зорилгоор “Хамтран ажиллах гэрээ”, “Засвар үйлчилгээ хийх график хуваарь”-ийг батлуулж, 3 дугаар улирлын байдлаар 3 удаа үзлэг хийж, засвар, үйлчилгээнд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлж, хяналтын 12 камерт засвар үйлчилгээ хийсэн.

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭХ ТАСАГ: Тус Цагдаагийн газраас иргэн хуулийн этгээдээс 2022 онд 2508 зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авснаас 2022 оны 3 дугаар улиралд 841 сарын гомдол мэдээлэл хүлээн авсан байна. Үүнээс 132 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 516 гомдол, мэдээллийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлж, 447 хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 10 гомдол мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн.

Хүлээн авсан нийт 841 гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шалгасан ба ажиллагаанд 14 гомдол мэдээлэл хуулийн хугацаанд шалгагдаж байна. Хугацаа хэтрүүлэн шалгасан гомдол мэдээлэл байхгүй.

Хялбаршуулсан журмаар 2022 оны 3 дугаар улиралд 447 хүнд 144,615,000₮ төгрөгийн торгууль оногдуулж шийдвэрлэсэн.

Нийт шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээллийн 99 буюу 11.77 хувийг зөрчлийн ахлах байцаагч, байцаагч, 742 буюу 88.23 хувийг бусад зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчид шалгаж, шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд зөрчлийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 26,516,006 төгрөгийн хохирлоос 21,366,006 төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 80,7 хувьтай байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэгт зааснаар зөрчилд холбогдогч шийтгэврийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор шийтгэлийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд баривчлах шийтгэлээр солиулах тухай саналыг 2 удаа гаргаж, шүүхээр торгуулсан 15 хэрэгт 21 иргэнээс нийт 2.520.000 төгрөгөөр торгуулийг нөхөн төлүүлж, 2 иргэний торгууль төлөх хугацаа дуусаагүй байна.

Долоо хоногийн хугацаанд зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, алба хаагчдын ажлын ачаалал, гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэргийн шийдвэрлэлт, хугацааны байдалд дүн шинжилгээ хийж, 5 өдөр бүр бие бүрэлдэхүүнд танилцуулах ажлыг хэвшүүлээд байна.

ЧОЙБАЛСАН ХОТЫН УНДНЫ ЭХ ҮҮСВЭРИЙГ ХАМГААЛАХ ТУСГАЙ САЛБАР:

Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах тусгай салбарын алба хаагчид батлагдсан томилгооны дагуу 2022 оны 03 дугаар улиралд “Дорнод нийтийн аж ахуй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай байгуулсан харуул хамгаалалтын ажлын гэрээнд заасны дагуу улсын онц чухал объектын харуул хамгаалалтад 405 удаа 9720 хүн/ цагийн харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэсэн.

Салбарын харуулчин, ахлагч нар улсын онц чухал объектын шалган нэвтрүүлэх 1-р пост, хяналтын 2,3-р постонд албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа цэвэр усны анги хориотой болон ариун цэврийн бүсэд өдрийн болон өглөө оройн ээлжинд гарч ажилласан 1376, гаднаас албан ажлаар нэвтэрсэн 140 хүний бичиг баримт болон биед үзлэг шалгалт хийж нэвтрүүлэн, 496 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийж, 4463 хөдөлгөөн хяналтад авч, зориулалтын бус газраар нэвтрэхийг оролдсон 21 зөрчил, объектод тогтоосон дэглэм журам зөрчсөн 3, нийт 24 зөрчлийг тус тус илрүүлэн шийдвэрлэж ажиллалаа.

Улсын онц чухал объектын хамгаалалтын нөхцөл байдлын талаар Дотоодын цэргийн штабын жижүүр Марал-10 болон цагдаагийн газрын жижүүрт тогтмол танилцуулж, үүрэг чиглэл авч ажиллаж байна. Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн харуулчин, ахлагч нарын ажлын хариуцлага, албаны сонор сэрэмжийг цагдаагийн газрын ёс журмын эргүүл, салбарын захирагч, хариуцлагатай эргүүлүүд нийт 145 удаа шалгаж, тодорхой үүрэг чиглэл бичгээр өгч, биелэлтийг тооцон ажиллалаа.

Салбарын хариуцлагатай эргүүлийг 24 цагаар томилон улсын онц чухал объектын харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын сонор сэрэмж, албаны бэлэн байдлыг тогтмол шалгаж, хамгаалуулагч байгууллагын удирдлагад хамгаалалтын үйл ажиллагааны мэдээлэл болон хамгаалуулагч байгууллагын ажилчдаас илрүүлсэн зөрчил, харуул хамгаалалтад ашиглагдаж байгаа инженер техник хэрэгслийн засвар үйлчилгээ бусад шаардлагатай зүйлийн талаарх мэдээллийг албан бичгээр өгч, хариуг тооцон, улсын онц чухал объектод нэвтэрч байгаа ажилчдын биеийн халууныг хэмжиж бүртгэл хөтлөн, гарыг ариутган нэвтрүүлж амны хаалтгүй ажилтныг нэвтрүүлэхгүйгээр буцаан хамгаалуулагч байгууллагын удирдлагад танилцуулж, заавар зөвлөмж хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Шалган нэвтрүүлэх байр болон хяналтын цэгүүдэд ариутгал цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж, үүрэг гүйцэтгэх хугацаанд амны хаалтыг тогтмол зүүж хэвших талаар үүрэг, ажлын чиглэл өгч, хамгаалуулагч байгууллагатай хамтран ариутгал, халдваргүйтгэлийг 7 хоногт 2 удаа хийж нийт 24 удаа халдваргүйжүүлэлт хийн, тогтоосон дэглэмийг сахиулан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Дотоодын цэргийн анги, тусгай салбарын 2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний дагуу тус цагдаагийн газрын холбооны инженер цагдаагийн хошууч В.Болормаа, харуулын дарга, хошууч Б.Гэрэлчулууны хамтаар Улсын онц чухал объектын хамгаалалтын харуулын цэгүүдээр явж холбоо, телехяналтын камер, компьютер, техник тоног төхөөрөмжид үзлэг хийж, илэрсэн зөрчлийг засах чиглэлээр хамтран ажиллалаа.

Улсын онц чухал объектын Цэвэр ус хангамжийн ангийн 1 дүгээр өргөгчийн инженер техникийн хэрэгсэлд хамгаалуулагч байгууллагын машинаст, харуулчин ахлагч нар хамтарсан үзлэг шалгалт хийж, Хяналтын 2, 3 дугаар цэгийн гаднах гортиг, хамгаалалтын хашааны өргөст тор унжсан, тасарсан хэсгийг бүрэн бүтэн болгон, Гүний 8-р худгийн урд “Хориотой бүс” гэсэн тэмдэг 2 ширхэгийг хийж байршуулан, Шалган нэвтрүүлэх цэг, харуулын даргын өрөөнд нэгдсэн интернетийн төхөөрөмж байршуулан, телехяналтын камерыг бүрэн ажиллагаанд оруулан засварлаж ажиллалаа.

Тус салбараар “Үзлэг-хяналт, шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг санаачлан удирдамж, төлөвлөгөөг боловсруулан Цагдаагийн газрын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус арга хэмжээний хүрээнд 2022.09.08-ны өдөр томилгоот үүрэг гүйцэтгэсэн харуулын бүрэлдэхүүн үзлэг шалгалт хийж ажиллах хугацаанд Хяналтын 3 цэгийн орчимд 1 иргэн явааг саатуулан шалгахад БНХАУ-ын иргэн Улаанбаатар хотоос хүн тосох гэж байгаад төөрсөн гэх тайлбартай явж байсныг шуурхай арга хэмжээ авч Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албанд болон Дотоодын цэргийн штабт мэдэгдэж уг этгээдийг Цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгч ажилласан

В. СЭТГЭЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан ЦБҮАЖ-ийн /код-938/-д заасны дагуу алба хаагчид сэтгэл зүйн тусламж дэмжлэг үзүүлэх үйлчилгээний чиглэлээр цагдаагийн алба хаагчийн сэтгэл зүйн байдлыг судлан оношлох, цагдаагийн байгууллагын алба хаагч, ажиллагсдад зориулсан сэтгэл зүйн сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, алба хаагч, ажиллагсдын хүсэлтээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал болон дэмжих бүлгийн ярилцлага хийх, мэргэжлийн тусламж, үйлчилгээний явцад гарсан асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, удирдлагад мэдээлэл өгөх, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтад мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах, мэргэжлийн мэдлэг, чадвараа хөгжүүлэх, шинийг санаачилж, хэрэгжүүлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулж ажиллалаа.

Алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг тодорхойлох, ажлаас халшрах хам шинжийн судалгааны дүгнэлтэд үндэслэн сэтгэл зүйн тусламж үзүүлэх, алба хаагчдын ажлын онцлог байдлыг үнэлж дүгнэн, хийж хэрэгжүүлэх ажлыг тодорхойлох зорилгоор Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн цахим санд байршуулсан сэтгэл зүйн судалгаанд давхардсан тоогоор нийт 284 алба хаагч хамрагдсан ба судалгааны үр дүнг боловсруулан ажиллав.

Алба хаагчдын стресс, сэтгэл гутрал, сэтгэл түгшүүр, ажлаас халшрах хам шинжийн хоорондын хамаарлыг судлах, статистик дүн шинжилгээ хийж хамаарлын түвшинг тогтоох зорилгоор SPSS программ¹-ыг ашиглах дүн шинжилгээ хийж ажиллалаа.

Дээрх судалгааны дүнд үндэслэн ажлаас халшрах хам шинжийн хэт өндөр илрэлтэйгээр судлагдсан 7 алба хаагчтай сэтгэл зүйн ярилцлага хийж, сэтгэл зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч, стрессийн түвшин өндөр, сэтгэл гутралтай 11 алба хаагчид зөвлөмж бичиж ажилласан.

Сэтгэл зүйн байдлыг илрүүлэх судалгаанд стресс, сэтгэл гутроын түвшин өндөр судлагдсан алба хаагчид тухайн албан тушаалд томилогдоод 1-2 жил болсон байгаа нь ажлын туршлага бага, тухайн албан тушаалд мэргэшээгүй, мэргэжил арга зүйн хувьд дутмаг байдал нөлөөлж байгаа тул

шинээр томилогдсон, шинээр болон албан тушаал өөрчлөн ажиллаж байгаа алба хаагчдыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох” журмын /код-944/- ын хэрэгжилтийг ханган, энэ онд шинээр томилогдсон 2 алба хаагчид сэтгэл зүйн зөвлөмж, зөвлөгөө өгсөн.

Алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Бие хүний хоорондын харилцаа ба ёс зүй, мэргэжлийн онцлогоос шалтгаалах сэтгэл зүйн өөрчлөлт”, “Харилцаанд тулгамддаг асуудал, түүнийг даван туулах арга зам” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

Тус цагдаагийн газрын “Дорнод цагдаа-Алба хаагчдын чөлөөт индэр” цахим хаягт эрүүл мэнд, сэтгэл зүйн багаас алба хаагчдын эрүүл мэнд, сэтгэл зүйн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор цахим зөвлөмж 2, сэтгэл зүйн мэдээлэл 5 удаа байршуулан ажиллаж байна.

Г. АРХИДАН СОГТУУРАЛТАЙ ТЭМЦЭХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР: Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 105 дугаар тогтоолоор “Архигүй дорнодчуудын төлөө” хөтөлбөрийг батлуулан дээрх хөтөлбөрийн хүрээнд 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөө удирдамжийг боловсруулан аймгийн засаг даргаар батлуулан хэрэгжүүлэн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 2022 онд 60.0 сая төгрөгийг / үүнээс архины сайн дурын эмчилгээнд 50.0 сая/ иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал оруулан танилцуулсанаар дээрх төсвийн тус тус батлуулжээ.

Согтуугаар үйлдэгдэх, гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулах иргэдийн амар тайван амьдрах, аюулгүй байлдлыг хангах чиглэлээр нутаг дэвсгэрийн хэмжээнд “Гудамж хяналт” “Зөвшөөрөлгүй архи спирт хяналт”, “Архи хяналт шалгалт”, “Такси хяналт шалгалт”, “Иргэн таны төлөө” “Хууль бус архи хяналт”, “Тэнэмэл иргэд”, “Эргүүл шалгалт”, “Шагийн архи”, “Тайван хот-Таны оролцоо” “Архигүй аймаг-Архигүй орчин”, “Хууль бус архи”, зэрэг нэгдсэн арга хэмжээ, хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулсан.

Дээрх нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийн хүрээнд хэрлэн сумын 6-р багийн 24, 25-р байруудын байрнуудын такси зогсоол дээр иргэд архи согтууруулах ундааг гар дээрээс хууль бусаар, шөнийн цагаар бусдад худалдан борлуулдаг зөрчлийг илрүүлэх таслан зогсоох чиглэлээр тус цагдаагийн газраас ажлын хэсэг томилон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг сар бүр зохион байгуулж тухайн нутаг дэвсгэрт 2 автомашинтай 6 алба хаагч, Замын цагдаагийн хөдөлгөөнт постыг байршуулан ажилласнаар нийт 156 зөрчил илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 6.5-р зүйлийн 13 дахь хэсэгт зааснаар 113 иргэнийг тус бүр 50,000 төгрөгөөр буюу нийт 5,650,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулан ажиллалаа.

“Архигүй Дорнодчуудын төлөө” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр Цагдаагийн газрын ажлын хэсэг, Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газруудтай хамтран төлөвлөгөөт шалгалтыг аймгийн 13 сумдад улирал тутамд буюу 2, 5, 9, 11 дүгээр саруудад нэг сарын хугацаатайгаар батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу ажилласан.

Дорнод аймгийн 13 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийтийн эргүүлд татан оролцуулах, ажилд “Архигүй Дорнодчуудын төлөө” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, ажлын хүрээнд давхардсан тоогоор нийт 316 аж ахуй нэгж байгууллагын 3401 иргэдийг нийтийн эргүүлд татан оролцуулан нийгмийн хэв журам сахиулах чиглэлээр ажлуулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөршийн холбооны үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр арга хэмжээнүүдийг зохион байгуулж, аймгийн ГХУСАЗСЗ, Хэрлэн сумын ГХУСАЗСЗ-өөс дэмжлэг үзүүлэн, шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулан ажиллав.

Хэрлэн сумын баг хариуцсан хэсгийн байцаагч нараас архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулж байгаа байгууллагуудад 11 удаагийн үзлэг шалгалтыг хийж, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тухайн байгууллагуудын захирал, эрхлэгч нартай уулзаж хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Архидан согтуурахтай тэмцэх, нийт 68 төрлийн сэрэмжлүүлэг, шторк, нэвтрүүлэг зэргийг орон нутгийн “TV-6”, “Мижи”, “Нутаг 21”, “Дорнод ТВ” зэрэг телевизүүд, Найрамдал Парк, Хэрлэн сумын 3 дугаар багт байх дэлгэцэнд тогтмол явуулж, аймгийн Төрийн болон төрийн бус байгууллагуудын урсдаг самбарт байрлуулж, Жаран.мн сайт болон “Дорнодчуудын нэгдэл”, “Дорнодын нэгдсэн зар”, “Дорнод Улаанбаатар явна ирнэ” зэрэг 73 группүүдээр 578657 иргэнд түгээлт хийж ажиллалаа.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр багт байрлах Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төвийн байрны зориулалтаар 2008 онд барьж ашиглалтад оруулсан, аймгийн Эрүүл мэндийн газрын дансанд бүртгэлтэй, 44м.кв төмөр хашаатай, 1 давхар 264 мкв барилгыг 2021 оноос Зүүн бүсийн Албадан эмчилэх төв байгуулахтай холбогдуулан зориулалтыг өөрчилөн Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх газрын харъяанд шилжүүлэн 35 хүн хэвтэн эмчлүүлэх хүчин чадалтай 652 сая төгрөгийн төсөвтэй, 22 орон тоотой албадан эмчилэх төв байгуулсан.

Одоогоор архины хамааралтай 60 иргэнийг судалгаанд авч эмнэлэгийн анхан шатны үзлэгт оруулан архины албадан эмчилгээнд хамруулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг А.А-ын 6 бүлэг, Монголын АА нийгэмлэгийн Зүүн бүсийн үйлчилгээний хороотой хамтран ажиллах аулын хүрээнд баривчлагдсан иргэдэд “Архины хор уршиг”, “Архинаас татгалзахуй”, “Архи бидний найз биш” зэрэг сургалтуудыг Монголын АА нийгэмлэгийн Зүүн бүсийн үйлчилгээний хорооноос зохион байгуулж, Сэргэлэн суманд 1 удаагийн цугларалт зохион байгуулж үйл ажиллагаа явуулж иргэдэд нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулахад Цагдаагийн газраас хамтран ажилласан.

Аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт согтуугаар зөрчил гаргасан, гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчиж шүүгчийн шийдвэрээр баривчлах шийтгэл хүлээсэн этгээдүүдэд “Албадан сургалт”-ыг тогтмол зохион байгуулж, холбогдох хууль эрх зүйн болон урьдчилан сэргийлэх сургалт мэдээллийг олон нийтэд сурталчилах ажлыг эрчимжүүлэв.

“Эдгэрэлийн баяр хөөр” төрийн бус байгууллагын мэргэжилтэн, сургагч багш С.Батболд “Төлөвшилтын шинжүүд” сэдвээр, “Архинаас татгалзах арга” сэдвээр, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сургалт хариуцсан ажилтан Э.Мөнхтунгалаг нартай хамтарч “Би амьдралд хайртай” “Архины хор нөлөө” сэдвээр, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай”, “Баривчлах байрны дотоод журам”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт”, “Зөрчлийн тухай хууль” зэрэг сэдвүүдээр архины хамааралтай иргэдийн зан чанарт нөлөөлөх сургалтыг 356 этгээдэд давхардсан тоогоор 11 удаа зохион явуулсан.

Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг А.А-ын 6 бүлэг, Монголын АА нийгэмлэгийн Зүүн бүсийн үйлчилгээний хороотой хамтран тус Цагдаагийн газраас үйл ажиллагааг нь дэмжиж сум дундын цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч нарт Монголын АА нийгэмлэгийн Зүүн бүсийн үйлчилгээний хорооноос сумдад ажиллах үед нь зохион байгуулалтын болон бэлтгэл ажлыг хангаж, дэмжлэг үзүүлэх талаар албан тоот, үүрэг чиглэл хүргүүлэн хамтран ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд “Архины хор уршиг”, “Архинаас татгалзахуй”, “Архи бидний найз биш” зэрэг сургалтуудыг Монголын АА нийгэмлэгийн Зүүн бүсийн үйлчилгээний хороотой хамтран зохион байгуулж 02 дугаар сард Сэргэлэн суманд зохион байгуулж нийт 68 иргэн хамрагдсан, 05 дугаар сард Матад суманд 53 иргэн, 09 дүгээр сард Дашбалбар суманд 110 иргэн, 11 дүгээр сард Цагаан-Овоо суманд 79 иргэн тус бүр 1 удаагийн цугларалт зохион байгуулж нийт 310 хүн хамрагдан үйл ажиллагаа явуулж иргэдэд нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулахад Цагдаагийн газраас хамтран ажилласан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэхэд бүх нийтийн анхаарлыг хандуулж, оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сурталчлах зорилготой хөдөөгийн 13 сумдыг хамарсан “Архигүй Дорнодчуудын төлөө” сэдэвт гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулах ажилд нийт 4 сая төгрөгийн зардлыг шийдвэрлүүлж тус арга хэмжээ 2 сард амжилттай зохион байгуулж төлөвлөгөөний хэрэгжилтийг тухай бүр ханган ажилласан.

Сайн дураар архи согтууруулах ундаа хэрэглэх хорт зуршлаас татгалзсан 6 иргэнийг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран 2021 онд “Ажлын байрыг дэмжих” төсөл арга хэмжээ, “Залуучууд” хөтөлбөрт хамруулан ажлын байранд холбон зуучилан ажиллаж байна.

Д. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

ЧИГЛЭЛЭЭР: Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Хамтарсан баг”-ийн удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, салбар дундын зохицуулалтыг хангах, гишүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх, хохирогчид үзүүлдэг үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, цаашдын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, чиглэлээр хамтарсан багийн гишүүдийг чадавжуулах зорилгоор зөвөлгөөнийг тус цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нараас уг зөвөлгөөнийг зохион байгуулахаар төлөвлөн удирдамж төлөвлөгөөг гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Насанд хүрээгүй хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион явуулсан “Хамтарсан багаараа хөгжье, суралцье” зөвөлгөөнийг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг, Аймгийн засаг даргын орлогч бөгөөд хүүхдийн эрхийн хорооны дарга Ш.Ёл, нар урилгаар оролцов.

Мөн Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс зохион байгуулсан Жендерийн хүчирхийллийн эсрэг “Жаргалтай гэр бүл” арга хэмжээг цагдаагийн газрын фэйсбүүк болон аймгийн олон дагагчтай группүүд болон аймгийн Дорнод телевиз, ТВ6, МИЖИ телевиз, цагдаагийн газарт байрлах урсдаг самбараар нэвтрүүлж иргэд олон нийтэд хүргэн мөн цагдаагийн газрын фэйсбүүк хэрэглэдэг алба хаагч нар болон хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнуудад уриалга гарган арга хэмжээний хүрээнд хийгдсэн 26 шторк, постер, подкаст, видеог цагдаагийн газрын фэйсбүүк болон

олон хандагчтай 36-42 группт тухай бүр түгээсэн “Жаргалтай-гэр бүл” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүгчийн шийтгэвэрээр 7-30 хоног баривчлагдсан иргэдийн гэр бүлийн гишүүдийн хамт “Асуудлаа хамтдаа шийдье” фокус уулзалт хэлэлцүүлгийг Цагдаагийн газрын сэтгэл зүйч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Оюундарь, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын гэр бүлийн сэтгэл зүйч Б.Хэрлэнтуул нарын хамтаар 5 удаа зохион байгуулж ажилласан. Баривчлагдсан иргэдээс ажил хөдөлмөрт зуучлуулах санал гаргасан 4иргэнийг аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газарт холбон зуучилсан.

“Хамтарсан баг-хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан уг арга хэмжээний хүрээнд Хэрлэн сумын 11 багийн хамтарсан багтай хамтран гэр бүлийн хүчирхийллээр баривчлагдсан иргэдийн хаягаар очиж нөхцөл байдлын үнэлгээг хийж, дахин зөрчил гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан.

Кейс нээж ажиллаагүй багийн ажлын албанд мэдэгдэл өгч биелэлтийг тооцож ажилласан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан шторкийг томоохон зах, худалдааны төвийн дэлгэцээр гаргаж иргэдэд сурталчилж ажиллалаа. Мөн 6 төрлийн сэрэмжлүүлэг постерыг орон сууцны хорооллын орц, төмөр зам, дэлгүүрүүдэд байршуулах ажлыг зохион байгуулсан. Лайф, улз, Дорнын ундарга зэрэг цэвэр усны ХХК-тай хамтран иргэдийн өргөнөөр хэрэглэдэг цэвэр усны саванд байршуулан иргэдэд сурталчиллаа.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын нэгдсэн төлөвлөгөө гарган шүүхийн шийтгэвэрээр баривчлагдсан хүмүүст Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай” хуулиуд болон “Архи тамхины хор нөлөө”, “Гэр бүлийн хүчирхийлэл түүний шинж” сэдэвт сургалтыг 7 хоногийн Пүрэв, Баасан гарагт хуваарийн дагуу зохион байгуулж, нийт 79 иргэнийг хамруулаад байна.

Аймгийн хэмжээнд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээг жил, улиралаар гаргаж цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд тогтмол танилцуулж “Судалгаа хяналтын бүртгэл, судалгаа” /PATROL2/ цэсний субъектийн бүртгэлийн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн бүртгэл”-д энэ оны байдлаар 11 хүн нэмж бүртгэсэн. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас шалгагдсан хүн бүр дээр хувийн хэрэг нээн хяналт тавьж ажиллаж байна.

Цагдаагийн газрын мөрдөгч болон зөрчил шалгах эрх бүхий албан тушаалтан нарт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн эрүүл мэнд, амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл болон зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал”, “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчтой харилцах арга зүй” сэдэвт 3 сургалтыг 3 удаа орж 3ш гарын авлага бүхий өврийн дэвтэрийг бэлтгэн тараасан.

Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа нарт аюулын зэргийн үнэлгээний журам, бөглөх арга зүй сэдвээр 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс болон өөрсдийн бэлтгэсэн 9 шторк, постер, подкаст, видеог Дорнод цагдаагийн газрын фэйсбүүк болон олон хандагчтай 100-120 группт тухай бүр түгээлтийг хийж давхардсан тоогоор 897121 хүнд хүргэсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1.1, 34.1, Монгол улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэх журам”-ын дагуу хүлээн авч, үйлчлүүлэгчид үзүүлэх суурь үйлчилгээ, үйлчлүүлэгчийг асран хамгаалах, үйлчлүүлэгчийг тайвшруулах, сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, холбон зуучлах болон гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээнүүдийг үзүүлж ажиллалаа.

Е. ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР: Тус цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн нараас насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргаж төлөвлөгөөнд заагдсан ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн Ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсээс хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан улсын хэмжээнд зохион явуулж байгаа “Хичээл эхэллээ” ерөнхий арга хэмжээний хүрээнд салбар төлөвлөгөөг гаргаж ажиллаж байна.

Их дээд болон коллеж, ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлттэй холбогдуулан оюутан сурагч, хүүхэд багачуудыг гэмт хэрэг, зөрчил зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах ажлын эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Боловсрол шинжлэх ухааны газартай хамтран сум орон нутгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал, эрхлэгч,

нийгмийн ажилтан нарыг оролцуулан энэ оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 10:00 цагаас 11:20 цагийн хооронд цахим хурлын зохион байгуулав.

2022 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр “Хичээлийн шинэ жил” эхлэж байгаатай холбоотойгоор Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, цэцэрлэг тус бүрт алба хаагчийг томилон, мөн хүүхэд багачуудыг зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр замын гарц, уулзварт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийгмийн хэв журам сахиулах чиглэлээр тус тус үүрэг гүйцэтгэв.

Арга хэмжээний хүрээнд “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийн гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс сэргийлэх, сургуулийн орчинд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажилд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн сурагчдыг, чадавхижуулах сургалтыг энэ оны 9-р сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтын үеэр Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хэрлэн сумын 2-р сургуулийн нийгмийн ажилтан нарын алба хаагчид сургалт мэдээлэл хийж ажилласан.

“Хичээл эхэллээ” ерөнхий арга хэмжээний салбар төлөвлөгөөний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр Хэрлэн сум ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 10 дугаар ангийн 4 бүлэгийн 94 сурагчид Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мөрдөн байцаах тасгийн ахлах мөрдөгч нарын алба хаагчид “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тухай ойлголт” сэдвээр тус тус сургалт мэдээллийг хийсэн.

“Дотруу байр” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол соёл шинжлэх ухааны газрын алба хаагчид 2022 оны 09 дүгээр сарын 06-наас 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулан ажилласан.

Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газраас улсын хэмжээнд зохион явуулж байгаа “Сэрэмжүүлэе” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Насанд хүрээгүй хүнийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлэгийг тус цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нараас уг хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөн удирдамж төлөвлөгөөг гаргаж Цагдаагийн газрын даргаар батлуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр “ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУУДАС”-ыг шинээр хийж хэсгийн байцаагч, төлөөлөгч, багийн иргэдийн ажлын албанд тус тус хүргүүлсэн.

Дорнод аймгийн Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны 7058102 тусгай дугаарын утас болон хүүхэд хамгааллын 108 дугаарын утсанд иргэдээс удаа дараа гэр бүлийн хүчирхийлэлийн талаар давтамжтай ирүүлсэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрээр гаргаж Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгааг гарган тухайн иргэдэд дахин зөрчил үйлдэхгүй байх урьдчилан сэргийлэх чиглэлээр 16 иргэнд эрх зүйн зөвлөгөө өгч дахин зөрчил үйлдэхгүй байх талаар баталгаа гаргуулан авч сургалт зохион байгуулан ажиллаж байна. Давтан зөрчил гаргасан иргэдийн гэрийн хаягаар эргүүлийн чиглэлд хамруулан 7 хоног бүрийн 2 өдөрт оройн цагаар гэрт нь очиж шалгуулан нэг бүрчилсэн хяналтыг тавин ажиллаж байна.

ГУРАВ. САХИЛГА ХАРИУЦЛАГА, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВИЛГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ТАЛААР

А. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаарын 28-ны өдрийн А/201 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”, дэд даргын 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 3/284 дугаартай үүргийн хэрэгжилтийг хангах, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэх, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Дүрэмч ажиллагаа-бидний соёл 2022” аяныг тус тасгаас 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 45 хоногийн хугацаатай зохион байгуулан ажиллаж байна. Уг аяны хүрээнд цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрэм болон бусад хууль, тогтоомжийн талаар сургалтуудыг зохион байгуулж байна.

Цагдаагийн газрын 2022 оны 03 дугаар улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг сумдын цагдаагийн тасаг, хэсэг, хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг хамруулан онлайн цахим хэлбэрээр зохион байгуулж, алба хаагчдаас сахилга, ёс зүйн зөрчил дутагдалгүй ажиллах талаар баталгаа гаргуулан авч ажиллалаа.

Цагдаагийн газрын тасаг албадын дарга, ахлахууд нь газрын дотоод журмын дагуу “Ёс журам сахиулах эргүүл”-ийн үүргийг хуваарийн дагуу 24 цагаар гүйцэтгэж алба хаагчийн сахилга ёс

зүй зөрчсөн, цагдаач жагсаалч байдал, албаны шуурхай бэлэн байдал хангаагүй зөрчлийг илрүүлэн Цагдаагийн газрын “Сахилга, ёс зүйн дэд зөвлөл”-д шилжүүлэн шийдвэрлүүлэн ажиллаж байна. Зөрчил заагдсан алба хаагчдын зөрчлийг засуулж, зөрчлийг дахин давтахгүй байх талаар баталгаа гаргуулан авч шийдвэрлэжээ.

Мөн Цагдаагийн газраас алба хаагчдыг харилцааны соёл, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, сахилга ёс зүйн алдаа дутагдалгүй, гаргахгүй ажиллах зорилгоор 2022 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зохион явуулсан “Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлье” аяны хүрээнд тус тасгаас салбар төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг зохион явуулав.

Мөн алба хаагчдаас хүний эрхийг дээдлэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад бусдаас шан харамж авах, хувийн харьцаа тогтоох, хууль бус шийдвэр гаргах зэргээр авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажиллах талаар баталгаа гаргуулан авч, тасгийн дарга нараас өдөр тутмын хяналтыг тавьж ажиллалаа.

Алба хаагчдыг сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Цагдаагийн алба хаагчдын сахилгын дүрэм”, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд мөрдөж ажиллах талаар баталгаа гаргуулан авч, Цагдаагийн газрын даргын 02 тоот “Зөвлөмж” хүргүүлэн, бичгээр 7 үүрэг өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Цагдаагийн газрын алба хаагч бүрээр “Өөрийгөө хөгжүүлэх”, “Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх”, “Аюулгүй байдлаа хангах”, “Сахилга, ёс зүйг дээшлүүлэх” талаар хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө 2022 оны 01 дүгээр сард гаргуулан биелэлт, үр дүнг улирал бүр тооцон ажиллаж байна.

Цагдаагийн газрын удирдлагаас алба хаагчдын гаргасан зөрчлийн шинж байдалд тулгуурлан сургалтын хэлбэрүүдийг сонгон мэргэшүүлэх, дадлагажуулах, мэдлэг олгох, гоо зүй, соёлын хичээл сургалт, зөрчил гаргасан алба хаагчдаар бие бүрэлдэхүүнд алдаан дээрээсээ суралцах сургалтуудыг оруулж, тэдний гэр бүлийн гишүүн бүртэй уулзаж сэтгэлзүйн зөвлөгөө өгүүлж, зөрчил дутагдалгүй ажилласан алба хаагчдыг сайшаах, сайн чанаруудыг нь хамт олонд сурталчлах ажлыг зохион байгуулж ажилласнаар 2022 оны гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, сахилгын зөрчил гаргаж, арга хэмжээ авагдсан алба хаагч байхгүй байна.

Б. Авилгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар, түүний үр дүн:

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын шалтгаан нөхцөлийг судлан тогтоох, болзошгүй үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, иргэд олон нийт, төрийн бусад байгууллага руу чиглэсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж, авлигын индексийн түвшинг бууруулах зорилгоор салбар төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаа.

Тус цагдаагийн газрын угтах үйлчилгээнд ажиллах алба хаагч нарт цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх зорилгоор иргэдийг угтан авч өргөдөл, гомдлын хугацаа, шалгаж буй албан тушаалтны мэдээлэл, хууль зүйн зөвлөгөө өгч, уулзахаар ирсэн иргэдэд жижүүрийн цагдаа зааж өгч нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хэвшсэн. Мөн <http://www.dornod.police.gov.mn/> цахим хуудсанд иргэдийг хүлээж авах хуваарийг байршуулсан.

Иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах ажил арга хэмжээнд Дэд бөгөөд эрүүгийн тасгийн дарга хяналт тавьж сар газрын даргад танилцуулан ажиллаж байна. Иргэдээс санал хүсэлт авах санал хүсэлтийн хайрцгийг хэлтсүүдэд байрлуулж газар, хэлтсийн даргаас өөр алба хаагч онгойлгох боломжгүй болгож, иргэдийн санал хүсэлтийг цаг алдалгүй түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэж ажиллаж байна. 2022 оны эхний 9 сарын байдлаар байгууллагын албан ёсны цахим хуудсаар иргэнээс ирүүлсэн гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Цагдаагийн газарт шинээр томилогдсон 14, ахлагчаас офицерын бүрэлдэхүүнд орсон 1, ахлах албан тушаалд 1, ажлын байр өөрчлөгдсөн 25 нийт 41 алба хаагчийн асуудлыг шийдвэрлэн ажил үүргээ хэвийн гүйцэтгэж байна. Ковидын үеийн төрийн албаны томилгоог /шагнал урамшууллыг зөвхөн байгууллагын хэмжээнд/ судлан, шалгаж хуульд заасан шаардлага хангаагүй албан тушаалын томилгоо байхгүй болно. Алба хаагчдыг судлах, томилох, албан тушаал дэвшүүлэх ажлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, төрийн албаны мерит зарчмыг баримтлан ажиллаж байна. 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Төрийн албанаас зөвлөлөөс зохион байгуулж буй “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын өөрчлөлт, бүтээмжийг дэмжих” 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр “Хөрөнгө оруулга, ашиг сонирхлын мэдүүлэг”, 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Хөрөнгө оруулга, ашиг сонирхлын мэдүүлэг”, зэрэг 5 удаагийн цахим сургалтад амжилттай хамрагдсан.

Цагдаагийн газрын алба хаагчдаас Гомдол, мэдээллийг хянан шалгаж, шийдвэрлэх, хууль сахиулах үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн оролдлого гарсан тохиолдолд авлигаас татгалзах талаар эрх бүхий 185 алба хаагчаас баталгаа авсан. “Авлигаас урьдчилан сэргийлэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” /код-139/-ын 139.61 “в” маягтын дагуу тэмдэглэл хөтөлж, мэдээлсэн тохиолдолд тасгийн дарга, ахлах нараас байгууллагын даргад мэдэгдэж урамшуулах талаар алба хаагчдад мэдэгдэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд цагдаагийн газрын алба хаагч нараас авлига ашиг сонирхлын зөрчил дутагдал гаргасан алба хаагч байхгүй байна. Хөтөлбөрийн дагуу “Авлигад өртөж болзошгүй эрсдэлтэй албан тушаал, түүнд ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрт хяналт тавих албан тушаалтны судалгаа”, “Авлигад өртөж болзошгүй алба хаагчдын судалгаа”-зэргийг гарган хяналт тавин ажиллаа УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт”-ын дагуу тус Цагдаагийн газраас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах эрх бүхий 95 алба хаагч мэдүүлгээ өөрийн биеэр, тогтоосон хугацаанд бүрэн гаргуулан авч хуулийн хугацаанд баталгаажуулан ажиллалаа.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, тайлбар, мэдэгдэл, мэдээлэл тэдгээрийн шийдвэрлэлт, хөрөнгө орлогын их хэмжээний өөрчлөлтийн бүртгэлийг маягтын дагуу бүрэн хөтөлж 2022 оны эхний 3 дугаар улиралд 38 алба хаагч хөрөнгө орлогын мэдүүлэг шинээр мэдүүлж, санд шивж баталгаажууллаа.

Хөтөлбөрийн дагуу “Авлигад өртөж болзошгүй эрсдэлтэй албан тушаал, түүнд ажиллаж байгаа алба хаагчид, тэдгээрт хяналт тавих албан тушаалтны судалгаа”, “Авлигад өртөж болзошгүй алба хаагчдын судалгаа”-зэргийг гарган хяналт тавин ажиллаа. Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага, нийт бие бүрэлдэхүүний үйл хэрэг болгон алба хаагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд заалт оруулж, авлигад өртөхгүй байх, удирдах албан тушаалтнуудын үлгэрлэл манлайлалтай ажиллаж, алба хаагч нарт тавих дотоодын хяналт, зарчимч шаардлагыг өндөржүүлэн ажилласнаас гадна авлигын хор уршиг, ашиг сонирхлыг зөрчил, түүнээс ангид байхыг уриалж хамт олноороо авлигыг тэвчиж ажиллахыг санал болгон гарын үсэг зуруулан авлигад өртөхгүй байх баталгааг гаргуулж ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээллийн мөрөөр Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай бүрэлдэхүүн дуудлагад очсон хугацаа, ажлын үр дүн, харьцааны соёл, хэрхэн шийдвэрлэсэн талаар тухай өдрийн Ёс журмын эргүүл дуудлага өгсөн иргэн бүртэй утсаар холбогдон санал хүсэлтийг сонсож, дуудлага мэдээлэл шалгалгүй дарагдуулсан, гомдолтой дуудлага мэдээллийг дахин шалгуулахаар хоногийн мэдээнд тусган иргэдийг санал хүсэлтийг сонсож ажилласнаар иргэдийг чирэгдүүлэх, дуудлага мэдээлэл дарагдуулах зөрчил дутагдал буурч байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

В/ Зохион байгуулсан соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ

Тус Цагдаагийн газраас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ журам, Цагдаагийн газрын 2022 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Цагдаагийн газрын даргын тушаалын хавсралтаар 2022 онд зохион байгуулах “Тэмдэглэлт баяр, ёслолын арга хэмжээ”, “Биеийн тамир спортын уралдаан тэмцээн”, “Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ”-ний хуваариудыг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мэдээлэл, сурталчилгааны ажлын хүрээнд: Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Соёл, соён гэгээрүүлэх ажил /код 940/” журам, Цагдаагийн газрын 2022 оны соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дагуу Цагдаагийн газрын алба хаагчдад ЦЕГ, харьяа албад болон аймаг, сумын төр захиргааны байгууллагаас ирүүлсэн бодлого шийдвэр, хууль тогтоомж, үүрэг ажлын чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг Захиргааны удирдлагын тасгийн дарга тухай бүрт нь танилцуулж мэдээллээр ханган ажиллалаа.

Эхний 3 дугаар улирлын байдлаар мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд 27 удаа 5053 алба хаагчдад мэдээлэл хийж, 31 удаа бичиг баримт, шийдвэрийг нийт давхардсан тоогоор 4942 алба хаагчдад танхимаар болон цахимаар мэдээлэл хийж танилцуулав.

Цагдаагийн газрын алба хаагч нарын илтгэх ур чадварыг сайжруулах, харилцааны соёлыг дээшлүүлэх, улс орны болон гадаад орон, аймаг орны онцлог үйл явдал, дотоодод зохион байгуулагдсан ажил, арга хэмжээний “ДОЛОО ХОНОГИЙН СУРВАЛЖЛАГА” мэдээг цагдаагийн газрын эмэгтэй алба хаагчдаас бэлтгэн 7 хоног бүрийн “Даваа” гарагт нийт 13 удаа давхардсан

тоогоор 2427 алба хаагчдад, “Долоо хоногийн криминологи судалгаа”-ны танилцуулгыг ахлахуудаас 13 удаа 2064 алба хаагчдад танилцуулан ажилласан байна.

Цагдаагийн газраас Монгол улсын Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Төрийн албаны сахилга дэг журам, ажлын хариуцлагыг чангатгах тухай 258 дугаар тогтоолыг иргэдийн хүлээлгийн танхимд байршуулж, хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцож ажиллалаа.

Цагдаагийн газрын удирдлагаас албадын үйл ажиллагааг сайжруулж, оршиж буй алдаа дутагдлыг засаж арилгах, ажлын хариуцлага сахилгыг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг зөв зохистой зарцуулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулах чиглэлээр албан даалгавар 9, зөвлөмж, зааварчилгааг 4, газрын даргын 36 үүрэг бичгээр, ажлын чиглэлийг албан бичгээр хүргүүлж, биелэлт үр дүнг долоо хоног бүр тооцон ажиллаж байна. Алба хаагчдын хуулиар хүлээсэн үндсэн үүргээ хэрэгжүүлэх, гэр бүлдээ зарцуулах цагийг нэмэгдүүлэх зорилгоор цахимаар үүрэг чиглэл өгөх, нөхцөл байдлын мэдээтэй танилцах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллав.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдахгүй байх, авилга, хүнд сурталтай холбоотой зөрчил дутагдал гаргахгүй байх талаар Цагдаагийн газрын дарга болон тасгийн дарга, удирдах дарга нараас бие бүрэлдэхүүнд өдөр бүр үүрэг, ажлын чиглэлийг цахимаар хүргүүлэн ажиллалаа.

Цагдаагийн газрын алба хаагчдыг иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй түргэн шуурхай, харилцааны өндөр соёлтой үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор газрын үүдний иргэдэд үйлчлэх өрөөнд байрлуулсан “Байгууллагын ил тод байдлын самбар”, “Авилгаас урьдчилан сэргийлэх самбар”-ын мэдээллүүдийг оны эхэнд шинэчилж, цагдаагийн алба хаагчийн хүнд суртал, авилга хээл хахуулийн талаарх мэдээллийг хүлээн авах утасны дугаар бүхий зурагт хуудсыг иргэдийн нүдэнд харагдахуйц газарт байрлуулж, санхүүгийн болон хүний нөөцийн талаарх мэдээллийг сар бүр тавьж иргэд, олон нийтэд ил тод нээлттэй хүргэж ирлээ.

Соёл, хүмүүжлийн ажлын хүрээнд: Цагдаагийн газрын хэмжээнд 18 удаа ажил, арга хэмжээ зохион байгуулж, 3401 алба хаагчдыг хамруулан ажиллаа.

Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг 3 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 500 алба хаагч хамрагдлаа.

Тус цагдаагийн газраас “Дорнод бүсийн эрчим хүчний эрчим хүчний салбар” ТӨХК-тай 2022 онд хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн байгуулж, алба хаагчдын бие бялдар, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр спорт зааланд хичээл сургалт, дасгал хөдөлгөөнийг долоо хоногийн “Пүрэв” гаригт тогтмол хийж ажиллаж байна.

Улсын ерөнхий прокурорын орлогч, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга нарын хамтран баталсан “Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл 60 хоногийн хугацаанд зохион байгуулж байгаатай холбогдуулан Мөрдөн байцаах тасгаас шийдвэрлэх хэргийн графикт орсон хэргүүдийг бүрэн шийдвэрлэн үр дүнтэй ажилласан.

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Итгэвэл шалга” арга хэмжээний зурагт хуудас, постер, видео шторкийг тогтмол “Дорнод аймаг дахь Цагдаагийн газар” фейсбүүк цахим хуудсаар дамжуулан иргэдэд түгээн энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, цаашлаад энэ төрлийн гэмт хэргийн оролцогч болохоос сэргийлэх зорилгоор 7 хоног бүр аймгийн хэмжээний олон дагагчтай группт байршуулан түгээн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс зохион байгуулсан Жендерийн хүчирхийллийн эсрэг “Жаргалтай гэр бүл” арга хэмжээг тус аймагт 2022 оны 01 дүгээр сард зохион байгуулж уг арга хэмжээнд ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Х.Туяасансар, сэтгэл зүйч, цагдаагийн ахлах дэслэгч Ц.Оюундарь, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын гэр бүлийн сэтгэл зүйч Б.Хэрлэнтуул нар хамрагдаж ажилласан.

Аймгийн засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/133 дугаар захирамжаар батлагдсан “Бод мал-2022” нэгдсэн арга хэмжээ эхэлсэнтэй холбогдуулан Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн алба хаагчид, Аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн нар, Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Мал эмнэлэг үржлийн тасаг, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй 2022 оны 03 дугаар сарын 10-ний өдөр уулзалт, зөвлөгөөнийг цагдаагийн газрын хурлын зааланд зохион явуулж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний талаар мал хулгайлах гэмт хэрэг мөрдөн шалгах ажил хариуцсан мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч Э.Зоригт “Мал хулгайлах гэмт хэргийг мөрдөн шалгахад анхаарах асуудлын” талаар 1 цагийн мэдээлэл хийж ажилласан.

Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд зохион явуулсан “Сэрэмжлүүлье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Насанд хүрээгүй хүнийг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 04 дүгээр сард тус цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасгийн алба хаагчид Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нартай хамтран зохион явууллаа.

Хэлэлцүүлэгт Аймгийн прокурорын газар, Аймгийн Засаг даргын тамгын газар, Хэрлэн сумын засаг даргын тамгын газар, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсрол

шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Зөв чигийн зөвлөхүүд, нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын ажилтан, алба хаагч нар оролцсон.

Тус цагдаагийн газраас Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, тэдний эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад хамтарсан багийн оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн Улсын зөвлөгөөн"-ийг угтан "ХАМТАРСАН БАГААРАА ХАМГААЛЪЯ, ХАМТДАА ХӨГЖЬЕ, СУРАЛЦЪЯ" зөвлөгөөнийг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн, ХЭҮК-ийн ИНЗ-ийн гишүүн Д.Ундраа "Хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хэрхэн ажиллах, хамтын ажиллагааны уялдаа холбооны ач холбогдол"-ын талаар сургалт, мэдээлэл хийж сургалтад тасгийн алба хаагчид бүрэн хамрагдлаа.

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2022 02 дугаар сарын 24-ний өдрийн А/07 дугаартай тушаалаар батлагдсан "Залилах" гэмт хэргийг шуурхай илрүүлэх шийдвэрлэх урьдчилан сэргийлэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийн төлөвлөгөөнд тусгагдсан "Нуугдмал хөрөнгө илрүүлэлт" хэсэгчилсэн арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийг дуустал 60 хоногийн хугацаатай зохион явуулахаар Мөрдөн байцаах албаны Залилах гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс төлөвлөгөө боловсруулан ирүүлсний дагуу салбар төлөвлөгөө гарган, цагдаагийн газрын даргаар батлуулан арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион явуулсан.

Арга хэмжээний хүрээнд мөрдөн шалгах ажиллагааны явцад 20,788,000 төгрөгийг хөрөнгийг битүүмжлэн ажилласан.

Мөрдөн байцаах албаны даргаас 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 9/4491 дугаартай албан бичгээр ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу тус тасгаас Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг ахиулах зорилгоор "Нэг хором 2022" хэсэгчилсэн арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион явуулах төлөвлөгөөг боловсруулж, цагдаагийн газрын даргаар батлуулан ажиллаж байна.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсч хөгжсөний 100 жилийн ой, "Хандлага дор-Хүндлэл оршино" нөлөөллийн аяны хүрээнд нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагч, ажилтны бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор "Үндэсний бөх"-ийн барилдааныг зохион байгууллаа.

Цагдаагийн газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн багаас "Асралт үйлс" өрхийн эмнэлгийн их эмч Н.Энхмаатай хамтран эрүүл зөв хооллолтын талаар 1 цагийн сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор "domod tsagdaa surgalt" хаалттай фейсбүүк хаалттай хуудсанд байршуулж ажиллаа.

Алба хаагчдын алба хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг дэмжих чиглэлээр алба хаагчдын идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор фитнесээр хичээллэдэг алба хаагч нарыг хөхүүлэн дэмжин урамшуулдаг бөгөөд Дорноговь айгийн Замын үүд суманд зохион байгуулагдсан "Зүүн бүсийн 5 жилийн ойн Пауэрлифтингийн нээлттэй тэмцээнд эргүүгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Энхтөр -74кг-ын жинд "Цээж шахалт"-ын төрөлд мөнгөн медаль хүртсэн амжилт гаргасан байна.

Монгол Улсад Төрийн хяналтын тогтолцоо үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулсан "Волейболын тэмцээн"-д Спортын дэд мастер Б.Ядамжав ахлагчтай Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын баг тамирчид "ТЭРГҮҮН БАЙР" эзэлсэн.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах, цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагч, ажилтны бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, хөл бөмбөгийн спортыг хөгжүүлэх, зорилгоор зохион байгуулагдаж байгаа Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын 2022 оны Зүүн бүсийн "ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА" шалгаруулах тэмцээн Говьсүмбэр аймагт амжилттай зохион байгуулагдсан. Тэмцээнд Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Хэнтий Төв аймгийн Цагдаагийн газар, хэлтсийн баг тамирчид оролцож, "Тэргүүн" байранд цагдаагийн хурандаа Т.Ганзориг даргатай Дорнод аймаг дахь Цагдаагийн газрын баг тамирчид шалгарч аваргын шилжин явах цом, алтан медаль, Өргөмжлөлөөр шагнагдсан.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсч хөгжсөний 100 жилийн ой, "Хандлага дор-Хүндлэл оршино" нөлөөллийн аяны хүрээнд "Намар эрүүл цагдаа-гэр бүл" өдөрлөгийн үйл ажиллагааг "Баянтүмэн натурал виллаж" амралтын бааз

дээр Цагдаагийн газрын хамт олон, гэр бүлийн дунд зохион байгуулж Өдөрлөгөөр тасгууд мэндчилгээ, хүүхдийн гар зургийн уралдаан, дартс шидэлт, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, хөгжөөнт буухиа тэмцээний төрлөөр хурд хүч, авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдөж, нийлбэр дүнгээр Мөрдөн байцаах тасаг 1 дүгээр байр, Дотоодын цэргийн тусгай салбар 2 дугаар байр, Замын цагдаагийн тасаг 3 дугаар байранд тус тус шалгарлаа.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсч хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд “Намар эрүүл цагдаа-гэр бүл” өдөрлөгийн үйл ажиллагааг “Энх зуслан” амралтын бааз дээр Цагдаагийн газрын хамт олон, гэр бүлийн дунд зохион байгууллаа. Өдөрлөгөөр тасгууд мэндчилгээ, хүүхдийн гар зургийн уралдаан, дартс шидэлт, холимог гар бөмбөгийн тэмцээн, хөгжөөнт буухиа тэмцээний төрлөөр хурд хүч, авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдөж, нийлбэр дүнгээр Мөрдөн байцаах тасаг 1 дүгээр байр, Дотоодын цэргийн тусгай салбар 2 дугаар байр, Замын цагдаагийн тасаг 3 дугаар байранд тус тус шалгарав.

Нийтийн хэв журам хамгаалах тасгаас “Хандлага дор хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд харилцаа, хандлагаа өөрчлөхөд чиглэсэн “Инээмсэглэлийн өдөр” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд өглөө ажилдаа ирж буй алба хаагч нартай ёсолж хүндлэн, эерэг сайхан үгсээр мэндчилэн угтаж, амин дэм, витамин тараасан байна. Мөн нийт алба хаагч нарт смайл тарааж, өөрт хамгийн эерэг мэдрэмж төрүүлдэг, бусдад үргэлж инээмсэглэл бэлэглэдэг алба хаагчдад бэлэглэх арга хэмжээг зохиож, “Хамгийн эелдэг алба хаагч”-ийг шалгаруулж, урамшууллаа.

Мөн “Уучлалын 7 хоног” арг хэмжээг зохион байгуулан 7 хоногийн хугацаанд хамгийн их зөрчил гаргасан болон ажлаас хоцрох, таслах, зан харилцаны хувьд доголдол гаргасан алба хаагчдыг бие бүрэлдэхүүний өмнө уучлалт гуйлгаж, ахин зөрчил дутагдал гарахгүй байхаар баталгааг авч ажилласан. Цагдаагийн газрын үүдний хэсэгт “Уучлалт хүсэж, сэтгэлээ нээх зүрх”-ийг байрлуулж зурвас бичих боломжоор хангаж ажилласан ба 38 алба хаагч захиа бичиж үлдээсэн байсаныг нэр дурдагдсан алба хаагчид гардуулан өгч хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэн ажилласан байна.

Дорнод аймгийн цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасагт эргүүлийн цагдаагаар ажиллаж байгаа цэргийн байнгийн тэтгэвэрт гарсан цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч С.Энхбаатарыг урьж “Мэдлэгээ хувуулцъя” 7 хоногийн арга хэмжээний хүрээнд цагдаагийн газрын нийт ахлагч бүрэлдэхүүнд “Харилцаа хандлага”, “Алба хаагчдын ур чадвар” гэсэн 2 сэдвийн хүрээнд чөлөөт байдлаар өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн талаар мэдээлэл солилцсон.

Цагдаагийн газрын дарын 6/59 дугаар тушаалаар Дорнод аймгийн Баян-Уул сум дахь сум дундын цагдаагийн тасгийн хэсгийн цагдаагийн албан тушаалд томилогдож, цагдаагийн дэд ахлагч цолоор шагнагдсан Х.Чулуун-Эрдэнийг цаашдын ажилд нь амжилт хүсэж цагдаагийн ахлах ахлагч С.Энхтөгөлдөр цагдаагийн эрдэм мэдлэгийг болон тус газрын жижүүрийн шуурхай удирдлагийн тасаг, эрүүгийн цагдаагийн тасаг, замын цагдаагийн тасаг, захиргаа удирдлагийн тасаг, зөрчил шалган шийдвэрлэх тасаг, нийтийн хэв журам хамгаалах тасаг, дотоодын цэргийн тусгай салбар, эрүүлжүүлэн саатуулах байр, шүүхийн хамгаалалтын байрны үйл ажиллагаа, эрүү, хэв журмын болон багуудийн нөхцөл байдлыг танилцуулан сурган дадлагажуулах, албаараа бахархах эерэг нөлөөллийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээх, урлаг гоо зүйн соёлыг төлөвшүүлэх зорилгоор ажил, мэргэжлээрээ бусдыгаа манлайлан ажилласан 21 алба хаагчдыг Дорнод хөгжимт Драмын театрын шинэ уран бүтээл “Нүдтэй наран тамга” хөгжимт драмын жүжгийг үзэж сонирхуулсан.

“Ёс зүйгээ мөрдөж, дүрмээ биелүүлцгээе” 30 хоногийн аяны хүрээнд Нийтийн хэв журам хамгаалах тасгаас зохион байгуулж буй “Манай хамт олон” арга хэмжээнд МУ-ын гавьяат жүжигчин “Соёл-Эрдэнэ- Өргөө” хамтлагийн гоцлол дуучин С.Бархас, “Харш” хамтлагийн гоцлол дуучин СТА Б.Баярт нарыг урьж оролцууллаа. Ирсэн зочид алба хаагч нарт хандан хамт олон хэрхэн бүрдэх, цагдаагийн алба хаагч үүргээ гүйцэтгэхдээ харилцаа ёс зүй, эрхэмлэх зүйлийн талаар санаа бодлоо илэрхийлж, зөвлөмж өгч, харилцан ярилцсан юм. Арга хэмжээний төгсгөлд дуучдаас алба хаагч нарт зориулж хит болж байсан дуунуудаар ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн.

Ахмадын сангийн данс нээлгэж 2022 оны төсөв 15.9 сая төгрөг батлуулж, Сар шинийн баярын арга хэмжээнд 115 ахмад ажилтанд 3.0 сая төгрөгийн гарын бэлэг, 3 ахмад ажилтанд ууцны хонь, 3 ахмад ажилтанд “Буянтай буурал” -аар өргөмжлөл тавгийн идээг тус тус гардуулан хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соёл, Соён гэгээрүүлэх ажил" /Код-940/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан "Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газраас ахмад үеэсээ үлгэр дуурайлал авч албандаа хандах хандлага, албаараа бахархах сэтгэгдэл бий болгох зорилгоор Монгол цэргийн нэгдсэн холбооны Дорнод аймаг дахь салбар холбооны нэрэмжит "АХМАД ДАЙЧДЫН ӨДӨРЛӨГ" ёслолын арга хэмжээ 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Тусгаар тогтнолын талбай дээр зохион байгуулагдлаа. Өдөрлөгт аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөр, Монгол цэргийн нэгдсэн холбооны Дорнод аймаг дахь салбар холбооны дарга, Засаг дарга М.Бадамсүрэн, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг болон бусад цэргийн хүрээний байгууллагуудын дарга нар, ахмад ажилтнууд оролцож, хошой баатар, маршал Хорлоогийн Чойбалсангийн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүллээ. Арга хэмжээний хүрээнд цэргийн хүрээний анги байгууллагуудын ахмад ажилтан нар ёслолын жагсаалаар жагсаж, салбартаа хөдөлмөрөө үнэлүүлсэн зарим ахмад ажилтнууд төрийн болон салбар хороо, аймгийн шагналаар шагнагдсан юм.Тус Цагдаагийн газрын ахмад ажилтан, цагдаагийн бэлтгэл ахмад Д.Дарийм Чойбалсан хотын "Тэргүүний ажилтан" цол тэмдэг, цагдаагийн бэлтгэл дэд хурандаа Б.Өнөржаргал, бэлтгэл дэд хурандаа Я.Цолмонбаяр нар Цагдаагийн газрын даргын "Баярын бичиг", мөнгөн шагналаар шагнагдлаа. Мөн ёслолын арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцсон цагдаагийн бэлтгэл хошууч Х.Болдбаатар даргатай Цагдаагийн газрын дэргэдэх "Ахмадын хороо"-ны хамт олон "Дэд" байранд шалгарч, "Өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнууллаа.Өдөрлөгийн төгсгөлд цэргийн хүрээний анги байгууллагуудаас урлагийн хэсэгчилсэн тоглолт үзүүлж, цагдаагийн ахлагч Э.Базаргүр "Аминаас үнэтэй тангараг" дуугаар нийт ахмадууддаа мэндчилгээ дэвшүүллээ.

Соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэх, алба хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдар, албаны бэлтгэлжилтийн түвшнийг ахиулах, эрүүл, өв тэгш бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор "Эрүүл, спортлог мөрдөгч" аяныг 2022 оны 03 дугаар сарын 10-ний өдрөөс эхлэн зохион байгуулж удирдамж төлөвлөгөөг цагдаагийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.

Арга хэмжээг эрүүл мэнд, спорт уралдаан, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, сургалт соён гэгээрүүлэх зэрэг чиглэлээр төлөвлөгөөнд тусгасан ажил, арга хэмжээг зохион явуулж байна.

Тухайлбал: Цагдаагийн газрын 1 дүгээр байрны сургалтын заалны үүдний хэсэгт тус тасгаас санаачлан "АЛДРЫН БУЛАН" тохижуулан, тамирчин алба хаагчдын алдрыг таниулан сурталчлах, алба хаагчдын спортоор хичээллэх дур сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр цагдаагийн газрын Цагдаагийн газрын спортын цол, зэрэгтэй алба хаагч нарт хүндэтгэл үзүүлэх "Бидний бахархалт тамирчид" арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Мөрдөгч нарын хамтын ажиллагааг сайжруулах, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, ажилд нь дэмжлэг үзүүлэх, албандаа хүндэтгэлтэй хандах сэтгэхүйг төлөвшүүлэх, дарга, ахлахын манлайлал, хяналтыг дээшлүүлэх зорилгоор мөрдөгч нарыг ахлах мөрдөгч нараар ахлуулан багт хувааж, хариуцсан мөрдөгчдийн өдөр тутмын ажилд тасгийн дарга, ахлахууд хяналт тавьж, "Мөрдөгч нарын ажилд хяналт тавьсан дэвтэр"-ийг боловсруулан тэмдэглэл хөтлөн зааварчилга, зөвлөмж өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна.

Мөрдөн байцаах албаны даргын 01 дугаартай албан даалгавар, тус албаны Захиргааны удирдлагын хэлтсийн даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 12а/599 тоот зөвлөмжид тусгагдсан соён гэгээрүүлэх ажлыг хэрэгжүүлэх, алба хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдар, албаны бэлтгэлжилтийн түвшнийг ахиулах, эрүүл, өв тэгш бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор "Эрүүл спортлог мөрдөгч" аяныг 2022 оны 03 дугаар сарын 10-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай зохион байгуулж удирдамж төлөвлөгөөг цагдаагийн газрын даргаар батлуулан төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллаж байна.

Алба хаагчдын ажлын хариуцлага, харилцаа, хандлага, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ар гэр, ахуй амьдралтай танилцан тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, санал хүсэлтийг сонсох зорилгоор "Гэр бүлээ сонсьё" арга хэмжээг зохион байгуулж, гэр бүлийн гишүүдийн дунд "Волейбол"-ын тэмцээнийг зохион байгуулан ажиллалаа.

Мөн Цагдаагийн газрын 2021 оны сахилга, ёс зүйн зөвлөгөөн 2022 оны 02 дугаар сарын 20-ний өдөр зохион байгуулагдаж, зөвлөгөөний төлөвлөгөөний дагуу тус тасгаас ширээний "Теннис"-ны тэмцээнийг "ДБЭХС" ТӨК-ны спорт зааланд зохион явууллаа.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100,101 жил, Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ой, Нийтийн хэв журам хамгаалах албанаас зохион явуулж байгаа "Хандлага дор-Хүндлэл оршино" нөлөөллийн аяны хүрээнд "Намар эрүүл цагдаа-Гэр бүл"

өдөрлөгийн арга хэмжээнд тус тасгийн алба хаагчид болон гэр бүлийн гишүүдийн хамт 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан.

Арга хэмжээнд тасгууд мэндчилгээ, хүүхдийн гар зургийн уралдаан, дартс шидэлт, хөгжөөнт буухиа зэрэг тэмцээн зохион байгуулагдан тус тасгийн алба хаагчид нийлбэр оноогоор “Нэгдүгээр” байр эзэлж ажилттай оролцлоо.

Цагдаагийн газраас зохион байгуулсан соёл, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг тухай бүр www.dornod.police.gov.mn вэб сайт болон “Дорнод аймаг дахь Цагдаагийн газар” пэйж хуудсуудад байршуулан иргэд, олон нийтэд түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Эхний 3 дугаар улирлын байдлаар соён гэгээрүүлэх ажлын хүрээнд мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн чиглэлээр нийт 45 удаа ажил, арга хэмжээ зохион байгуулан ажиллаж, 8454 лшлба хаагчдад хүргэн ажиллаж, соён гэгээрүүлэх ажлын биелэлт 97.8 хувьтай байна.

Г/ Зохион байгуулсан албаны сургалтын талаар: Дорнод аймаг дахь Цагдаагийн газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/02 тоот тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу Цагдаагийн газрын албаны сургалтын 2022 оны нэгдсэн болон үлгэрчилсэн төлөвлөгөөг цагдаагийн газрын даргаар батлуулж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх, хууль хэрэглэх чадварыг дээшлүүлэх чиглэлээр нэгдсэн болон мэргэжлийн холбогдолтой сургалтуудыг 7 хоног бүрийн “Лхагва”, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлж, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээнийг зохион байгуулж, албаны спортыг хөгжүүлж, албаны бэлтгэлийг хангах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой сургалтыг “Пүрэв” гарагуудад тогтмол явуулж ирлээ.

18 удаагийн сургалт зохион явуулж, нийт давхардсан тоогоор 2916 алба хаагч хамрагдаж, сургалтын ирц 96.7 хувьтай хамрагдлаа.

Бие бүрэлдэхүүнд мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалт 8, алба хаагчийг хөгжүүлэх сургалт 2, дадлагажуулах сургалт 2, Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт 6, танхимын болон дадлага сургалтыг 18 удаа зохион байгуулж, албаны сургалтын зардалд нийт энэ оны 03 дугаар улирлын байдлаар 625.000 төгрөгийг зарцуулав.

Цагдаагийн газрын хэмжээнд 2022 оны 3 дугаар улиралд шинээр томилогдсон 8 алба хаагчийг “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох хөтөлбөр хэрэгжүүлэх” /код 944/-д заасны дагуу томилогдсон албан тушаалд богино хугацаанд дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах чиглэлээр дадлагажуулагч багшийг тушаалаар томилон, алба хаах болон багш шавийн гурван талт гэрээг байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу 2022 оны 3 дугаар улиралд “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдал” цахим сургалтад 1, удирдах алба хаагчдын чадавхжуулах, Хүний эрхийн сургагч багшийн давтан сургалт, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн газрын үзлэг хийх, илрүүлэх арга так тик, Механикжсан тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн шалгалт авах замын цагдаагийн нэгжийн эрх бүхий алба хаагчийг чадавхжуулах зэрэг танхимийн сургалтад нийт 6 алба хаагч тус тус хамрагдлаа.

Дотоод хэргийн их сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилд шинээр 2 алба хаагч элсэн орж, “Цагдаагийн ажил эрх зүй” мэргэжлийн эчнээ сургалтад 9 алба хаагч суралцаж байгаа ба “Зохиомж” дээд сургуулийн эчнээ сургалтад шинээр 3 алба хаагчийг суралцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн хамруулав.

Цагдаагийн газраас 2022 онд зохион байгуулах нэгжийн сургалтын төлөвлөгөөний дагуу цаг сэдвийн хүрээнд боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр цагдаагийн газрын даргаар батлуулж, төлөвлөсний дагуу сар бүр 2 сургалтыг зохион байгуулж, Мөрдөн байцаах албанаас 2 удаа авсан сорилын шалгалтад алба хаагчдыг бүрэн хамруулж дүнг нэгтгэн хүргүүлж ажилласан.

“Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цахим хэрэглээний аюулгүй, зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор сургагч багш бэлтгэх” сэдэвт сургалтад тус тасгийн мөрдөгч, цагдаагийн дэслэгч Д.Гантөгөлдөр хамрагдсан.

Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар хамтран Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” сэдэвт зүүн бүсийн сургалтад тус тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад

Х.Туяасансар, мөрдөгч, цагдаагийн дэслэгч Л.Соронзонболор нарыг 2022 оны 05 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хамруулсан.

Аймгийн Прокурорын газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх С.Ариунааг урьж “Таньж олуулах ажиллагаа явуулахад анхаарах асуудал” сэдвээр 2022 оны 01 дүгээр сард тус газрын мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий алба хаагч нарт 2 цагийн сургалтыг зохион байгууллаа.

Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсээс зохион байгуулсан “Бага насны хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад анхаарах асуудал” сэдэвт сургалтад тасгийн алба хаагчид бүрэн хамрагдсан.

Тээврийн цагдаагийн албанаас энэ оны 06 дугаар сард зохион байгуулсан “Зам тээврийн осол, гэмтэлд мөрдөгчийн магадалгаа гаргах, хэргийн газрын үзлэг хийхэд анхаарах асуудал” сэдэвт сургалтад алба хаагчид цахимаар бүрэн хамрагдлаа.

Мөн Төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгс 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр “Төрийн алба хаагчийн ёс зүй, менежмент” сэдвээр 1 цагийн сургалт, Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн, доктор Д.Сүнжид “Хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албаны үйл ажиллагаа” сэдэвт 1 цагийн сургалтыг тус тус орж, тасгийн алба хаагчид бүрэн хамрагдсан.

Д.Мэдвэл зохих хууль, тогтоомжийн сургалтын талаар: Цагдаагийн газрын алба хаагчдад ЦЕГ, харъяа албад болон аймаг, сумын төр захиргааны байгууллагаас ирүүлсэн бодлого шийдвэр, хууль тогтоомж, үүрэг ажлын чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг Захиргааны удирдлагын тасгийн дарга тухай бүрт нь танилцуулж мэдээллээр ханган ажиллалаа. Мэдвэл зохих хууль тогтоомжийн сургалтыг 4 удаа явуулж, 648 алба хаагчид хамрагдсан ба 3 дугаар улирлын байдлаар 3 удаа бичиг баримтыг нийт /давхардсан тоогоор/ 648 алба хаагчдад мэдээлэл хийж танилцуулав.

Алба хаагчийг хөгжүүлэх сургалтын талаар: Алба хаагчдыг хөгжүүлэх сургалтыг 2 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 324 алба хаагч хамрагдлаа. Дорнод их сургуулийн гадаад хэлний тэнхимтэй алба хаагчдад “Англи хэлний анхан шатны мэдлэг олгох” чиглэлээр хамтран ажиллах чиглэлээр санал бодлоо солилцон хамтын гэрээ байгуулан ажиллалаа.

Дадлагажуулах сургалтын талаар: Төрийн болон Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтыг 6 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 972 алба хаагч хамрагдлаа.

Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн гишүүн Ц.Амартөгсөөр ахлуулсан ажлын хэсэг тус Цагдаагийн газарт хүрэлцэн ирж, 2 үе шаттай сургалтыг зохион байгуулж, тусгайлсан чиг үүрэг бүхий хүчний байгууллагын алба хаагч нарт зориулж, хууль эрх зүйн шинэчлэл шийдвэрийг хэрэгжүүлэх арга барилыг эзэмшүүлэх, төрийн алба хаагчдын хүлээх үүрэг, хүний нөөцийн чиглэлээр сургалтыг зохион байгууллаа. Дараагийн үе шатны сургалт болох “Хандлага дор хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд харилцаа, хандлагаа өөрчлөхөд чиглэсэн “Төрийн алба хаагчийн ёс зүй, менежмент” сэдвээр сургалтыг нийт алба хаагч нарт явуулав. Сургалтын үеэр Цагдаагийн алба хаагчийн иргэдтэй зөв боловсон харьцах харилцаа, чиг үүргийн талаар видео танилцуулгыг бие бүрэлдэхүүнд үзүүлж, санал солилцов.

Терроризмтой тэмцэх зөвлөл, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны зөвлөлийн хамтарсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон, терроризмын аюул занал” сэдэвт сургалтад тус цагдаагийн газрын дэд бөгөөд эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан ахлах байцаагч, эдийн засгийн ахлах мөрдөгч, ахлах мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, хэсгийн байцаагч, хүүхдийн асуудал хариуцсан байцаагч нарыг хамруулав.

Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын талаар: Алба хаагчийн бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтыг 3 удаа зохион явуулж, давхардсан тоогоор 500 алба хаагч хамрагдлаа.

Тус цагдаагийн газраас “Дорнод бүсийн эрчим хүчний эрчим хүчний салбар” ТӨХК-тай 2022 онд хамтран ажиллах гэрээгээ шинэчлэн байгуулж, алба хаагчдын бие бялдар, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр спорт зааланд хичээл сургалт, дасгал хөдөлгөөнийг долоо хоногийн “Пүрэв” гаригт тогтмол явуулж хэвшсэн.

2022 оны байдлаар биеийн тамир, спортын 5 арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулагдахаар төлөвлөн ажиллаж. Энэ оны эхний 03 дугаар улирлын байдлаар “Үндсэний бөх”, “Марш тактик”, “Буудлага”, тэмцээнүүдийг зохион байгуулан алба хаагчдын бүрэн хамруулж ажиллаа.

Иргэд, олон нийтэд чиглэгдсэн сургалтын талаар: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын нэгдсэн төлөвлөгөө гарган шүүхийн шийтгэвэрээр баривчлагдсан хүмүүст Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хүүхэд хамгааллын тухай”, “Зөрчлийн тухай” хуулиуд болон “Архи тамхины хор нөлөө”, “Гэр бүлийн хүчирхийлэл түүний шинж” сэдэвт сургалтыг 7 хоногийн Баасан гарагт хуваарийн дагуу нийт 13 удаа зохион байгуулж, 11 иргэнийг хамруулаад байна.

Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, мэдвэл зохих хууль тогтоомжийг судлуулах зорилгоор зохион явуулсан сургалт нэг бүрийг сургалтын мэдээллийн бүртгэлийн санд давхардуулалгүй, баяжилтыг хийж санг бүрдүүлэн ажиллаж, сургалтын материал нэг бүрийг гарын авлага болгон авч алба хаагч нэг бүрт судлуулах зорилгоор “Dornod tsagdaa SURGALT” сургалтын хаалттай цахим группт байршуулан зайны сургалтыг тогтмол, тасралтгүй зохион байгуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах, судлах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

ДӨРӨВ. САНХҮҮ, БҮРТГЭЛ, ХАНГАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

Байгууллагын санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар хийсэн ажил, арга хэмжээний талаар: Цагдаагийн газрын үйл ажиллагааны төсөвт улсын төсвөөс 3,458.8 сая төгрөг, өөрийн болон гэрээтийн орлогоор 70,8 сая төгрөг нийт 3,529.6 сая төгрөг батлагдсан, төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллаж байна.

Монгол улсын Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу үүссэн өр төлбөрийг барагдуулах, хэмнэгдсэн зардлаас байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бараа материал худалдан авах чиглэлээр батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах 20.0 сая төгрөгийн саналыг Цагдаагийн Ерөнхий Газрын Санхүү аж ахуйн албанд хүргүүлэн 10 дугаар сард шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, тогтмол болон бусад зардлын журналын бичилтийг сар бүр хийж төсвийн гүйцэтгэлийг тооцон судалж төсөвлөгдөөгүй өр авлага үүсгэхгүй байх талаар анхаарч, үүссэн өр авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан удирдлагад танилцуулан өөрийн орлогын төлөвлөгөөг 563.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн, 19.9 сая төгрөгийн өртэй, авлагагүй ажилласан.

Мөнгөн хөрөнгө: Алба хаагчдын цалинд 2.2 тэрбум, байгууллагаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 48.1 сая, байр ашиглалтын зардалд 34.3 сая, бичиг хэрэг 16,5 сая, шатахуун 99,3 сая, холбооны зардал 4.5 сая, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлийн зардал 3.3 сая, хоол, эм бэлдмэлийн зардал 0.2 сая, урсгал засварын зардал 36,0 сая, алба хаагчдад хөдөө орон нутаг болон хотруу албан ажлаар явсан алба хаагчдад томилолт 12,2 сая, байцаан шийтгэх ажиллагааны зардал 9,7 сая, тээврийн хэрэгслийн татвар 0.6 сая, газрын татвар 1.0 сая, сургалт дадлагын зардал 0,1 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 3.7 сая нийт 2.5 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж 81.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын зарцуулалт, эргэн төлөлтийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт, дотоод аудитын хэлтсээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг тооцон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг мэргэжлийн байгууллагын шинжээчээр дүгнэлт гаргуулахад 5.6 сая төгрөгийг олгож, буцаан гэм буруутай этгээдээр 450.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, бусад гарсан зардлыг төлүүлэх ажлыг эрчимжүүлэн байгууллагыг төлөөлсөн нэхэмжлэгчээр мэдүүлэг өгч материалд хавсарган ажилласан.

Тус цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн 100070012401 тоот дансанд аймаг орон нутгаас Олон нийтийн цагдаагийн ажилтаны урамшуулал, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөөнд орсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулал 89.6 сая төгрөгийг төвлөрүүлэн, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 02 дугаар хавсралт “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын дагуу нээлгүүлэн зориулалтын дагуу бүрэн зарцуулан ажилласан.

Цалин хөлс бүртгэл: Хөдөлмөрийн тухай хуулийн 60.1 “Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно” гэж заасны дагуу цалинг сард 2 удаа алба хаагчдын цалинг бодож урьдчилгаанд 955.8 сая төгрөг, сарын сүүлд 1,1 тэрбум төгрөгийг голомт, хас, төрийн банкинд байрших алба хаагчдын цалингийн дансанд шилжүүлэн олгосон. Алба хаагч, ажилтны цалинг бодож байгаа байдалд сар бүр, улирлаар давхар хоногийг шалган зөрчилийг тухай бүрт засуулан ажилласан.

Алба хаагчдын цалингаас шүүхийн шийдвэрээс бусад суутгал хийгээгүй ба албанаас шилжсэн болон албан тушаал өөрчлөгдсөн алба хаагч нартай эд хөрөнгө болон бусад тооцоог хийж дуусган тойрох хуудсыг авч 2 алба хаагчын мөнгөн хангалтын аттестатыг олгосон.

Алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг дүгнэж Цагдаагийн газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцэн цалин нэмж, хасч тооцон батлагдсан төсвийн хүрээнд олгосон. Харилцагч Голомт, Хас банкны удирдлагуудтай цалингийн болон орон сууцны зээлийн нөхцөл хүүд хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр уулзалт хийж алба хаагч нараас сэтгэл ханамжийн судалгаа авч мэдээлэл хийлгэн цалингийн зээлийг хүүг 1,1-1,2 хувиар байгуулан ажиллаж байна.

Санхүүгийн мэдээллийн ил тод байдал: Төсөв, санхүүгийн ил тод байдалын хүрээнд Цагдаагийн газрын төсвийн орлого, батлагдсан төсвийн зарцуулалтыг www.dornod.police.gov.mn сайтны шилэн дансны хэсэгт, www.shilendans.mn шилэн дансны сайт, байгууллагын санхүүгийн ил тод байдал гэсэн мэдээллийн самбарт 2022 оны жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, улирал, сарын төсвийн гүйцэтгэл, хагас жилийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсвийн хэтрэлт, хэмнэлт түүний шалтгааны тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр тус тус байршуулан албан хаагчид болон иргэд, олон нийтийг нээлттэй үзэх боломжоор бүрэн хангаж ажилласан 2022 онд худалдан авах хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөгөөг гарган батлуулан шилэн дансны сайтад мэдээллэн ажилласан.

Санхүүгийн мэдээллийн самбарыг шинэчлэн хийлгэн байгууллагын 1 дүгээр конторын үүдэнд байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, төсвийн гүйцэтгэлийн 1-9 сарын мэдээ, 2021 оны санхүүгийн аудитлагдсан тайлан, шилэн дансанд эхний хагас жилд мэдээлвэл зохих 111 мэдээллийг бүрэн байршуулан 100 хувийн биелэлттэй ажиллаж байгаа ба тайланг 3 удаа илгээн ажилласан.

Хөрөнгө оруулалт:

Байгууллагын 2022 оны төсвийн хөрөнгөөр түлш шатах тослох материал худалдан авах нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу www.tender.gov.mn сайтад цахимаар зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан **132.4** сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

- 2022 онд аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах ажлын хүрээнд Матад, Булган, Гурванзагал, Баяндун сумын цагдаагийн тасаг, хэсгийн алба хэрэгцээнд нийт 4 автомашин худалдан авах 125,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа цуцлаж төсвийн тодотголоор санхүүжилтийг татсан, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/-ны засварт 41,2 сая төгрөг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт тендэрийг зарлаж Дорнын их өглөг ХХК-тай гэрээ байгуулан Цагаан-Овоо сумын Цагдаагийн хэсгийн байрыг засварлуулан хүлээн авсан Сэргэлэн сумын хэсгийн байрыг 2022 онд засварлахаар ажиллаж байна.

-Хууль зүй дотоод хэсгийн яамнаас балансаас баланст шилжүүлсэн Ланд-200 маркын автомашиныг шилжүүлэх тогтоолыг гаргуулан данс бүртгэлд 167.7 сая төгрөгөөр бүртгэн авсан. Мөн Чойлбалсан хотын Засаг даргын тамгийн газраас согтуурал тандагч драйгер 20 ширхэг 27.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Номин даатгалаас автомашины даатгалын нөхөн төлбөрт 40.8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулан УАЗ-Мега ХХК-тай гэрээ байгуулан Уаз-Хантер маркын автомашиныг шинээр худалдан авч ашиглалтад оруулсан.

Цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагад шаардлагатай бараа материал худалдан авах ажиллагаанд үнийн судалгаа хийж хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласан.

Бараа материал, өмч хөрөнгө: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйл, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 422 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн “Бараа материалын бүртгэл” хэсэг, Цагдаагийн газрын даргын тушаалаар батлагдсан Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл байгууллагын данс бүртгэлд байгаа тусгай эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж 6 удаагийн хурал хуралдаж өмчийн ашиглалт хяналтын бүртгэл гарган үр дүнг тооцож ажилласан.

Албан тушаал, ажлын байр өөрчлөгдсөн алба хаагчдын ажил хүлээлцэх актаар эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хийж, ажил хүлээлцэх актыг санхүүд хүлээлгэн өгөөгүй алба хаагчдыг 5 дахь өдрийн санхүүгийн мэдээллийн цагаар танилцуулан ажилласан.

Цагдаагийн газрын даргын тушаалаар байгууллагын эд хөрөнгийг хэсэгчлэн тоолох ажлын хэсгийг томилон алба хаагч нарт эзэмшиж байгаа эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолон ажиллаж байна.

Албаны дүрэмт хувцасны хангалт: Албанд шинээр томилогдсон алба хаагч нарын томилгоо цол зэрэг албан тушаал өөрчлөгдсөн тухай бүр тушаалыг Хангалт үйлчилгээний хэлтэст хүргүүлэн алба хаагч нарын хөдөлгөөний баяжилтийг ахлах мэргэжилтэн х/ч Золзаяатай тулгалт хийж шинээр албан томилогдсон болон цагдаагийн 175 алба хаагчдад хантааз, бусад хангалтыг тараан олгосон. Цагдаагийн газраас өөрийн хүсэлтээр халагдсан цагдаагийн ахлах дэслэгч Г.Одхүү, Х.Нямдаваа, М.Сүхэрдэнэ, С.Энхтулга, М.Энхжаргал, Б.Ачхүү нарын хувцасны төлбөр барагдуулах ажлыг зохион байгуулан төлбөрийг төлүүлж Ц.Оюундарь, М.Төрболдын төлбөрийг төлүүлэх ажлын зохион байгуулав.

Автомашин, мотоциклийн талаар: Дорнод аймаг дахь цагдаагийн газрын албан ашиглагдаж байгаа авто машинуудыг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан "Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, газар, нэгжийн автомашины тоо, хоногийн гүйлтийн хэмжээ"-г мөрдөж, засвар үйлчилгээг чанартай хийх тал дээр анхаарч Жолооч нарын замын хуудас бөглүүлэх авто машины стометрийн залттай тулгалтыг сар бүр хийж Цагдаагийн газрын даргын тушаалаар баталсан техникийн комисстой хамтарч авто машины сэлбэг хэрэгсэл дээр акт үйлдэж Төсвийн тухай хуулийн 41.2.2, зам тээврийн хөгжлийн сайдын "Жишиг норм батлах тухай" 2019 оны 390 дүгээр тушаалыг үндэслэн Цагдаагийн газрын даргаар тушаал гаргуулан Цагдаагийн газрын данс бүртгэлд байгаа авто машинуудын 100 км гүйлтэд зарцуулагдах жишиг нормыг батлуулан хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Туслах мал аж ахуйн чиглэлээр ᠐᠗᠗᠔᠒ᠢ ᠶᠢ᠗᠗ ᠨᠠᠢᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨᠠᠳᠠᠳᠢ ᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠠᠵᠤᠳᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ 171 ᠶᠢ᠗᠗ ᠨᠠᠢᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ 136 ᠶᠢ᠗᠗ ᠨᠠᠢᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ 27,5 ᠶᠢ᠗᠗ ᠶᠢ᠗᠗᠔᠒ᠢ ᠠᠵᠤᠳᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠔᠔᠔᠗ᠶᠢ ᠵᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠵᠠᠳᠠ ᠴᠤᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠵᠢᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ 156000 ᠔᠔᠗᠔᠒ᠢ ᠔᠔᠔᠒ᠢ ᠠᠵᠤᠳᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠶᠢ᠗᠗ 4.290.000 ᠔᠔᠗᠔᠒ᠢ ᠶᠢ᠗᠗ ᠵᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠵᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ ᠵᠠᠶ᠋ᠠᠶ᠋ᠠᠨ. Малчны ахуй амьдрал гэрээний дагуу сард 2 төлөг, зарцуулдаг нь одоо үеийн зах зээлийн нийгэмд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй байсан тул оны эхнээс Цагдаагийн газрын дарга болон зөвлөлийн гишүүдэд танилцуулан 2 төлөг дээр нэмж 1 борлон ямаа олгохоор шийдвэр гаргуулан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан шийдвэрлэн ажилласан.

Туслах аж ахуйн 2022 оны төл бойжуулалтад анхаарч тасаг алба хаагчдын хүчээр нэмэгдүүлэн ажиллан унага 8, тугал 8, хурга 80, ишиг 75 толгойг тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгасан.

ТАВ. ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЛААР

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах /код 112/ журам"-ыг баримтлан тасаг, хэсгүүдийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн байдлаар учирч болох эрсдэл, хяналт шинжилгээ дүгнэлтийг хийж, түүний үндсэн дээр Цагдаагийн газрын "Дотоод хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө"-г гарган хэрэгжүүлж биелэлт үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн газрын удирдлага нь оны эхэнд "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг явуулах" /код 112/, Санхүүгийн дотоод хяналт шалгалт хийх журам /код 117/ Хууль зүйн сайдын 2015 оны а/238 дугаар тушаалаар батлагдсан "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-ын дагуу тасаг, алба, алба хаагчдын ажлын алдаа, зөрчил дутагдлыг засч арилгах, таслан зогсоох, ажлын хэвийн нөхцлийг хангах, чанар үр дүнг дээшлүүлэх, алба хаагчдын ажлын болон сахилга ёс зүйн дутагдлыг илрүүлэх, засуулах зорилгоор "Дотоодын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө" гарган алба хаагчдын ажлыг шалган зааварчлах ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022 оны 03 дугаар улиралд 4 ажлыг төлөвлөж хяналт шалгалтыг 7-10 хоногийн хугацаанд зохион байгуулж дүнг цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 4 хугацаатай үүрэг чиглэл хүргүүлж биелэлт үр дүнг тооцож ажиллаа. Нэмэлтээр Цагдаагийн газрын үнэт цаасны зарцуулалт, тооцоо тулгалтын байдал, Эд хөрөнгийн тооллого, Албаны шалгалтын материалын бүрдэлтийн байдалд хяналт шалгалтыг явуулж, Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн цаашид авч хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг, ажлын чиглэлийг өгч ажиллалаа.

ЗУРГАА. АЛБА ХААГЧ, АЖИЛТНЫ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН АСУУДЛЫГ ХАНГАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны зорилт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/112 тушаалаар батлагдсан “Хорт зуршлаас татгалзаж-Сайнаар үлгэрлэе” нөлөөллийн аян, Цагдаагийн ерөнхий газрын даргын А/155 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын соёл, эрүүл мэнд, сэтгэл зүйг төлөвшүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус Цагдаагийн газрын орон тооны бус “Эрүүл мэнд, сэтгэл зүйн баг”-аас БОЭТөвийн дотоод шүүрлийн тасгийн эрхлэгч эмч, анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч Д.Цэцэгмааг урьж, “Далд чихрийн шижин, түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр Эрүүл мэндийн газрын халдварт бус өвчлөлийн асуулал хариуцсан мэргэжилтэн Э.Бибишийг урьж “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах тухай танилцуулга” сэдвээр тус тус сургалтыг зохион байгууллаа.

Мөн өдөр тус Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүнд далд чихрийн шижинг илрүүлэх 1 удаагийн глюкозын ачаалалтай шинжилгээ авч, алба хаагч нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Алба хаагчдыг нөхөн сэргээх сувилалд хөнгөлөлттэй буюу төлбөргүйгээр эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн байдлыг харгалзан “Сүүж-Уул” сэргээн засах амралт сувилалд амраах алба хаагчийн судалгааг гарган өнөөдрийн байдлаар тус цагдаагийн газраас 1 ээлжинд 12 алба хаагчийг гэр бүлийн хамт амрааж сувилуулав.

Алба хаагчдыг түр болон удаан хугацаагаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд зориулж хамт олны “Журмын сан”-гаас эхний 03 дугаар улиралд 500.000 төгрөгийн мөнгөн тусламжийг 4 алба хаагчдад үзүүлсэн байна.

2022 оны хамтран ажиллах гэрээ, төлөвлөгөөний дагуу “Асралт үйлс” өрхийн эмнэлэгээс алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Эрүүл зөв хооллол”, “Давсны хэрэглээг зохицуулах ач тус”, “Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх” зэрэг сургалтыг зохион байгуулж сургалтын материалыг алба хаагч нарыг бүрэн хамруулах зорилгоор “dornod tsagdaa surgalt” хаалттай фейсбүүк хуудсанд байршуулж ажиллав.

Ахмадын сангийн данс нээлгэж 2022 оны төсөв 15.9 сая төгрөг батлуулж, Ахмадын баярын арга хэмжээнд 115 ахмад ажилтанд гарын бэлэг, 1 адуу, 1 ахмад ажилтныг "Алдар нь мөнхөрсөн ахмад буурал" -аар өргөмжлөл мөнгөн шагнал гардуулж хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Соёл, Соён гэгээрүүлэх ажил" /Код-940/, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/37 дугаар тушаалаар батлагдсан “Ахмад, дунд, залуу үеийн залгамж холбоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн газраас ахмад үеэсээ үлгэр дуурайлал авч албандаа хандах хандлага, албаараа бахархах сэтгэгдэл бий болгох зорилгоор 1996-1998 онд тус цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Д.Цэрэндорж “Дурсамж-уулзалт” арга хэмжээ зохион байгуулав.

Тус цагдаагийн газраас алба хаагчдын ажиллах орчин, нөхцлийг сайжруулах, дэвшилтэт техник технологийг алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлтэндээ ашиглах зорилгоор хамгаалуулагч байгууллага “Дорнод Нийтийн аж ахуй” компаниас дотоодын цэргийн тусгай салбарын алба хаагч нарт үүргийн радио гар болон суурин станц, шөнийн дуран, гар чийдэн, дрон зэргийг хүлээлгэн өгсөн.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс хийж гүйцэтгэхээр заагдсан 5 зорилт, 63 заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барилыг боловсронгуй болгох, бүрэлдэхүүний сахилга ёс зүйг дээшлүүлэх тэдний дунд зохиох сургалт соён гэгээрүүлэх ажил, алба хаагчдын нийгмийн асуудал, ажлын байрны тохижилтыг сайжруулах зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх журам”-ын /код 108/ дагуу 5 бүлэг 63 зорилт бүхий цагдаагийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэн ажиллалаа.

- 2022 онд аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумдын хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах ажлын хүрээнд Матад, Булган, Гурванзагал, Баяндун сумын цагдаагийн тасаг, хэсгийн алба хэрэгцээнд нийт 4 автомашин худалдан авах 125,0 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа цуцлаж төсвийн тодотголоор санхүүжилтийг татсан, Сэргэлэн, Цагаан-Овоо сумын цагдаагийн хэсгийн байр /Кобан/-ны засварт 41,2 сая төгрөг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт тендэрийг зарлаж Дорнын их өглөг ХХК-тай гэрээ байгуулан Цагаан-Овоо сумын Цагдаагийн

хэсгийн байрыг засварлуулан хүлээн авсан Сэргэлэн сумын хэсгийн байрыг 2022 онд засварлахаар ажиллаж байна.

-Хууль зүй дотоод хэсгийн яамнаас балансаас баланст шилжүүлсэн Ланд-200 маркын автомашиныг шилжүүлэх тогтоолыг гаргуулан данс бүртгэлд 167.7 сая төгрөгөөр бүртгэн авсан. Мөн Чойлбалсан хотын Засаг даргын тамгийн газраас согтуурал тандагч драйвер 20 ширхэг 27.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлсэн.

Номин даатгалаас автомашины даатгалын нөхөн төлбөрт 40.8 сая төгрөгийг шийдвэрлүүлэн автомашин худалдан авах ажиллагааг зохион байгуулан УАЗ-Мега ХХК-тай гэрээ байгуулан Уаз-Хантер маркын автомашиныг шинээр худалдан авч ашиглалтад оруулсан.

Монгол Улсад Цагдаагийн байгууллага үүсч хөгжсөний түүхт 100, 101 жил, Дотоодын цэрэг үүсч хөгжсөний 100 жилийн ой, “Хандлага дор-Хүндлэл оршино” нөлөөллийн аяны хүрээнд “Намар эрүүл цагдаа-гэр бүл” өдөрлөгийн үйл ажиллагааг “Баянтүмэн натурал виллаж” амралтын бааз дээр зохион байгуулсан.

Дорнод аймгийн Халхгол сумын Ялалт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ны үйл ажиллагааг “Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл” НҮТББ-ын тэргүүн Г.Адилбиш болон нэр бүхий нутгийн иргэд хамтран 5 шаардлага тавьж эсэргүүцэж газрын тосны тээвэрлэлт явуулдаг төв замд 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 13-ны өдрүүдэд жагсаалыг зохион байгуулагдах үед тус тасгийн алба хаагчид хэв журам сахиулах хамгаалалтын үүргийг гүйцэтгэн ажилласан.

- Аймгийн хэмжээнд 2022 оны 09 дүгээр сард 337 холбогдогчтой, 1.540.2 төгрөгийн хохиролтой, 533 гэмт хэрэг бүртгэгдэж, 140 хэргээр буюу 36 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 36.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 206 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 2 буюу 14 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 36 буюу 21 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 420.6 төгрөг буюу 27.3 хувийг нөхөн төлүүлжээ.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 112 бүртгэгдэж 47 буюу 72 хувь, Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 37 бүртгэгдэж 25 буюу 29.4 хувь, Галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин, хүүхэд оролцсон гэмт хэрэг 17 бүртгэгдэж 7.5 дахин тус тус өсөж

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг хэрэг 30 бүртгэгдэж 7 буюу 19 хувиар буурч, Мансуурсан үедээ үйдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 29 хүн холбогдсон нь 9 буюу 24 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 12 бүртгэгдэж 5 буюу 29,4 хувиар тус тус буурсан

Үйлдэгдсэн газраар: - Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 59 бүртгэгдэж 10 буюу 20 хувь, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 37 бүртгэгдэж 23 буюу 1.6 дахин, Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 5 бүртгэгдэж 4 буюу 4 дахин, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 47 бүртгэгдэж 22 буюу 88 хувь, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 33 бүртгэгдэж 7 буюу 27 хувь, бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 120 бүртгэгдэж 46 буюу 62.8 хувь, Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 22 бүртгэгдэж 1 буюу 5 хувиар тус тус өссөн байна.

Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 13 бүртгэгдэж 8 буюу 38.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийн төрлөөр: - Хүнийг алах 6 бүртгэгдэж 1 буюу 20 хувь, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 50 хувь, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 192 бүртгэгдэж 30 буюу 19 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 3 бүртгэгдэж 3 дахин, хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдэж 58 буюу 1.05 дахин, залилах гэмт хэрэг 78 бүртгэгдэж 32 буюу 70 хувь, Хөрөнгө завших гэмт хэрэг 13 бүртгэгдэж 4 буюу 44 хувь, гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 буюу 25 хувь, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах 1 бүртгэгдэж 100%, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100%, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 1 буюу 33.3%, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 18 бүртгэгдэж 1 буюу 6 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 11 бүртгэгдэж 4 буюу 57 хувиар өсч

Хүний амь насыг болгоомжгүй хохироох гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 буюу 50 хувь, бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 14 бүртгэгдэж 2 буюу 14 хувь, халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 1 буюу 20 хувь, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 21 бүртгэгдэж 3 буюу 14 хувиар тус тус буурч

Дээрэмдэх гэмт хэрэг 3, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж ижил түвшинд байна.

Хүүхдийн эсрэг, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, авлигын эсрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хулгайлах гэмт хэрэг 113 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 58 буюу 1.05 дахин өсөж үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 97 бүртгэгдэж 48 буюу 98 хувь өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 40 бүртгэгдэж 4 буюу 11 хувиар өссөн байна. гэмт хэргийн илрүүлэлт 36.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан байна

НАЙМ. ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ

1. Цагдаагийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
2. Алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж, сургалт, соёл, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион явуулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.
3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах.

ТАЙЛАН БИЧСЭН:
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ